

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2021 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2021.10.05

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчид 09 дүгээр сард 1 удаа хуралдаж 10 асуудал хэлэлцэж 12 тогтоол баталлаа. Үүнд:

1. Арга хэмжээ батлах тухай асуудлыг хэлэлцээд техник технологийн хөгжлийн хурдацтай, цахим эдийн засгийн шилжилт өөрчлөлтийн өнөө үед иргэдийн эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Иргэн та эдийн засагч” арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхээр баталлаа.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тухай хэлэлцээд “Соёл урлаг хүний хөгжилд” хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг “Хангалттай” гэж дүгнэлээ.

3. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нэр өөрчлөх тухай асуудлыг хэлэлцээд “Хөтөл-Ус” ОНӨААТҮГ-ын нэрийг “Гавшгай-Ус” ОНӨААТҮГ болгон өөрчлөн тогтоолоо.

4. Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцээд Мандал сумын Түнхэл тосгоны Захирагчийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Цагдаагийн кубоны барилгыг газрын хамт Хан Хэнтийн Улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаанд шилжүүлэхийг зөвшөөрөв.

5. Үндсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд Сайхан сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, мөн сумын Цагдаагийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг ашиглалтын хугацаа дуусаж, сэргээн засах боломжгүй болсон тул нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг тогтоолоо.

6. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталлаа.

7. Мал аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан Шаамар сумын малчин Сосорбарамын Лхагвааг “Монгол Улсын Хөдөлмөрийн баатар” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

8. Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан Сүхбаатар сумын ахмад настан, ахмад багш Чойжилзавын Хайнзанг “Монгол Улсын Гавьяат багш” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

9. Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан Сүхбаатар сумын ахмад настан, ахмад багш Цэвээндоржийн Цэгмэдийг “Монгол Улсын Гавьяат багш” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

10. Эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн дотор зүрх судасны кабинетийн их эмч Буянтогтохын Цэрэнлхамыг “Хүний гавьяат эмч” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

11. Нутгийн өөрөө удирдах байгууллага, хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан Жавхлант сумын ахмад настан Дашдоржийн Хэнмэдхэвхүүг “Сүхбаатарын одон”-оор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

12.Ардын хувьсгалын 100 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн салбартаа амжилт гаргасан зарим хүмүүсийг төрийн одон, медалиар шагнуулахаар уламжиллаа. Үүнд: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 11, Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор 1, Алтан гадас одонгоор 23, Цэргийн гавьяаны одонгоор 2, Хөдөлмөрийн хүндэт медалиар 79, Цэргийн хүндэт медалиар 1 хүнийг тус тус шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

13.Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ахмадын хороог ахмад дайчин, төр нийгмийн зүтгэлтэн, ахмадын хороог үүсгэн байгуулагч, Зүүнхараа хотын анхны дарга асан Норовын Намсрайн нэрэмжит болгон тогтоолоо.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх өдөр” буюу 2021 оны 09 дүгээр сарын 10-ны энэ өдөр аймгийн төв Сүхбаатар суманд оршин суудаг хэлмэгдэгсдийн ар гэр, төрөл төрөгсдийг хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.

“Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль”-д 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаас нэмэлт өөрчлөлт оруулснаар Улс төрийн хилс хэрэгт холбогдуулан цаазаар авах ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчдийн эхнэр /нөхөр/ эсхүл хэлмэгдэгчийн төрсөн болон үрчилж авсан хүүхэд, хэлмэгдэгчийг нас барснаас хойш 10 сараас илүүгүй хугацааны дотор төрсөн хүүхдэд 80.0 сая төгрөг, мөн хорих ялаар шийтгүүлсэн дээрх хүмүүст 40.0 сая төгрөгийн нөхөх олговор тус тус олгохоор тусгасан.

Одоогийн байдлаар энэ заалтын хүрээнд Сэлэнгэ аймгийн харьяат 43 нэхэмжлэгчдэд нөхөх олговор 2 тэрбум 84 сая төгрөгийг олгуулаад байна. Үүнийг он тус бүрээр задлан танилцуулбал, 2019 онд 6 нэхэмжлэгчид 281.0 сая, 2020 онд 34 нэхэмжлэгчид 1.683.0 сая, 2021 онд 3 нэхэмжлэгчид 120.0 сая төгрөгийн нөхөх олговор олгогджээ. Мөн манай аймгаас шүүхийн шийдвэр нь гарч Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст уламжлагдсан 24 нэхэмжлэгчийн 1 тэрбум 21 сая төгрөгийн нөхөх олговор хүлээгдэж байна.

Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг дэмжих төслийн баг манай аймагт ажиллалаа. Тус төсөл нь ядуурлыг бууруулах Японы сангаас санхүүжиж “Азийн Хөгжлийн банк”-ны бодлого журмын дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хэрэгжүүлж буй “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд хэрэгжиж буй “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг дэмжих” зөвлөх үйлчилгээний төслийг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, ХЗДХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газар болон Сэлэнгэ аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран хэрэгжүүлж байна.

Төслийн нэгдүгээр шатанд зорилтот орон нутаг /Увс, Сэлэнгэ, Сүхбаатар аймаг, Улаанбаатар хотын Налайх, Сонгиохайрхан дүүрэг/ тус бүрээс бизнес хийх, ажил хөдөлмөр эрхлэн орлогоо нэмэгдүүлэх хүсэлтэй, суралцах хүсэл тэмүүлэлтэй, оёдолчин, үсчин малчин, тариачин зэрэг тодорхой ажлын туршлагатай эсхүл ур чадвартай, төсөлд оролцох хүсэлтэй 25 эмэгтэйг төслийн оролцогчоор шалгаруулж, хоёрдугаар шатанд төслийн нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтад тэнцсэн зорилтот орон нутаг тус бүрээс 10 эмэгтэйг шалгаруулан төслийн үйл ажиллагааны дараагийн шатны сургалтад хамруулах, бичил тэтгэлэг олгох замаар тэднийг эдийн засгийн хувьд бие даах боломжийг олгох зорилготой юм.

Төсөл хэрэгжүүлэгч багийн гишүүд Сэлэнгэ аймгаас төслийн нэгдүгээр шатанд шалгарсан 25 бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн нөхцөл байдалтай танилцан, орчны ажиглалт үнэлгээг хийж байна. Үүний дараа төслийн хоёрдугаар шатанд шалгарсан 10 төсөл /10 эмэгтэй/ тус бүрд 2500 ам.долларын бичил тэтгэлгийг олгож эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхийг дэмжин ажиллах юм.

Алтанбулаг сумын халаалтын төвийн үйл ажиллагаа, хувьчлалын асуудлаар нийтийн сонсгол зохион байгуулж өгөхийг хүссэн тус сумын иргэн Ц.Болормаагийн хүсэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид хүлээн авч 09 дүгээр сарын 20-ны өдөр сонсголыг цахим хэлбэрээр зохион явууллаа.

Сонсгол зохион байгуулснаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тухайн асуудлын талаарх мэдээллийг оролцогч талууд болон холбогдох мэргэжлийн байгууллагуудаас илүү дэлгэрэнгүй сонсож, 09 дүгээр сарын 21-нд хуралдах аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ээлжит хуралдаанаар хэлэлцлээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Засаг дарга Ш.Оргил Шаамар суманд ажиллаж орон нутгийн нөхцөл байдалтай танилцаж, тус суманд баригдаж байгаа 25 айлын 5 давхар орон сууцыг Сүхбаатар суманд баригдаж ашиглалтад орсон 120 айлын орон сууцтай адил нөхцөлөөр Шаамар сумын төрийн албан хаагчдад олгож болох эсэх, МСҮТ-ийн ашиглагдахгүй байгаа барилгыг орон сууц болгон ашиглах судалгааг тус тус гаргаж танилцуулахыг сум орон нутгийн удирдлага, холбогдох мэргэжлийн байгууллагуудад үүрэг болголоо.

Мөн “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ыг үйл ажиллагаа, өвөлжилтийн бэлтгэлтэй танилцлаа. Тус байгууллага аймгийн төв Сүхбаатар болон Алтанбулаг, Цагааннуур, Ерөө сумын Бугант тосгоны хэрэглэгчдийг дулаанаар ханган ажилладаг. Аймгаас энэ хавар 150 сая төгрөгийн насосны хөрөнгийг шийдэж, нүүрсний уурхайгаас татан авалт хийхэд эхний ээлжинд яаралтай шаардлагатай байгаа урьдчилгаа 280 сая төгрөгийн асуудлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр шийдвэрлэлээ.

Аймгийн Засаг даргаас 2020-2021 оны хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан сурагчдыг 1.000.0 сая төгрөг, бэлтгэсэн багш нарыг 500.0 мянган төгрөгөөр тус тус урамшуулж, уг арга хэмжээг 5 дахь жилдээ зохион байгууллаа.

Аймгийн Онцгой комиссын гишүүн, Засаг даргын орлогч Ж.Сайнцог Зүүнбүрэн суманд ажиллаж, Зүүнбүрэн сумын үерийн нөхцөл байдал, Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг чиглэлд зам тавьж байгаа “Монгол ЛЗ зам гүүр” ХХК-ий ажил, намрын ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн ажлын явцтай танилцлаа.

УИХ-ын гишүүн Ч.Ундрам энэ сарын 8, 9-ний өдрүүдэд Сэлэнгэ аймагт ажиллаж, “Цаг уурын онцгой нөхцөлийг урьдчилан мэдэх, хөдөө аж ахуйд ашиглах арга зам” сэдвээр аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон цаг уур орчны шинжилгээний алба, сумдын Хөдөө аж ахуйн тасаг болон Мал эмнэлгийн тасаг нэгж нийлсэн нийт 115 төр, төсвийн байгууллагын албан хаагчдад явагдсан цахим сургалт зохион байгууллаа.

Монгол Улсын Шадар сайд, Улсын Онцгой комиссын дарга С.Амарсайхан Сэлэнгэ аймагт ажиллаж, Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг чиглэлд 128 км замыг тавихаар ажиллаж байгаа “Монгол ЛЗ зам гүүр” ХХК-ий ажлын явц байдалтай танилцаад холбогдох мэргэжлийн байгууллагуудаас бүрдсэн ажлын хэсгийг ирүүлж ажиллуулахаар боллоо. Мөн Шадар сайд аймгийн Онцгой комиссын ээлжит хуралдаанд оролцож, Засгийн газар, Улсын Онцгой комиссын бодлого шийдвэрийг орон нутагт хэрхэн хэрэгжүүлэн ажиллаж байгаатай, цар тахлын энэ цаг үед аймгийн Онцгой

комисс, Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Хилийн 0101 дүгээр анги зэрэг голлох салбарын байгууллагууд хэрхэн ажиллаж байгаа талаар танилцлаа.

Энэ үеэр аймгийн Онцгой комиссын дарга Ш.Оргил дараах саналыг уламжиллаа.

1.Халдварын тохиолдлын улмаас олон газарт ковидын тасаг нээн ажиллуулж байгаатай холбогдуулан зөөврийн рентгэн аппарат дутагдалтай, мөн Мандал сум хүн ам ихтэй улсын хамгийн том сум, халдварын тархалт буурахгүй байна. Иймээс Мандал суманд молекул биологийн шинэ лаборатори нээж ажиллуулах,

2. Манай аймаг хойд хилийн аймаг. Ковидын улмаас хил дагаж ажил амьдралаа авч явдаг олон хүмүүсийн ажил зогссон. Эхний ээлжид том машинаар ачаа тээврийн үйлчилгээ үзүүлдэг иргэдээ хилээр оруулж, гаргах бололцоо нөхцөлийг нь хангах талаар УОК тодорхой шийдвэр гаргаж өгөх талаар санал орууллаа.

Сэлэнгэ аймаг, БНХАУ-ын Хөх хотын хамтын ажиллагааны хүрээнд ээлжит цахим уулзалт явагдаж, цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан Эрүүл мэндийн салбарын чиглэлээр зохион байгуулагдлаа. Уулзалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Болорзул, аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Ц.Эрдэнэчимэг болон эмнэлгийн холбогдох албаны хүмүүс оролцлоо.

УИХ-ын гишүүн Ч.Ундрамын санаачилгаар МУ-ын Засгийн газар, БШУ-ны яамтай хамтарч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймгийн Ерөнхий боловсролын 30 сургуулийг Биологийн хичээл (лаборатори)-ийн иж бүрэн хэрэглэгдэхүүнтэй болголоо.

УИХ-ын гишүүн Ч.Ундрамын урилгаар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Элчин сайд М.П.Сингх манай аймагт албан айлчлал хийж, аймгийн Засаг дарга Ш.Оргил болон албаны хүмүүстэй уулзаж Сэлэнгэ аймагтай хэрхэн хамтарч ажиллах боломжтой талаар санал солилцож, аймгийн Засаг дарга хөдөө аж ахуйн салбар тэр дундаа өрхийн үйлдвэрлэлийн техник тоног төхөөрөмж, арга туршлагаас судалж суралцах, оюутан залуус, салбар салбарын мэргэжилтнүүдийг сурч боловсрох, мэдлэгээ сайжруулахад хамтран ажиллах хүсэлтээ илэрхийллээ. Элчин сайд М.П.Сингх Сэлэнгэ аймагтай хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах боломжтой, тэр тусмаа сүүний үйлдвэрлэл, багш, төрийн албан хаагчид, зарим хувийн хэвшлийн мэргэжилтнүүдийг сургаж, дадлагажуулах чиглэлд хамтран ажиллах боломжтой гэлээ.

Аймгийн Онцгой комиссын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабаас дэлхийн дахинд тархаад буй коронавирус /Ковид-19/-ын халдварын тохиолдол гарч, халдварлах эрсдэл бий болсонтой холбоотойгоор урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр Онцгой комиссын орлогч, Шуурхай штабын дарга, дэд хурандаа Г.Галбадрахаар ахлуулсан Онцгой байдлын газар 9, Цагдаагийн газар 2, Мэргэжлийн хяналтын газар 3, Эрүүл мэндийн газраас 1 нийт 18 албан хаагч өглөөний 09:00-21:00 цаг хүртэл ажиллан дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Журмын хавсралтыг өөрчлөн батлах тухай” 118, “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай”259, “Хилийн Алтанбулаг боомтын талаар авах арга хэмжээний тухай” 184, “Улсын хил нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоосон хугацааг сунгах тухай” 228 дугаар тогтоол, “Ажлын хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 778 дугаар албан бичиг, Улсын Онцгой комиссын 2021 оны 46 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хот болон орон нутаг хооронд зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”, аймгийн Онцгой комиссын 2021 оны 26, 27 дугаар тогтоолыг

хэрэгжүүлэх зорилгоор сумдын Онцгой комиссын дарга нарт үүрэг чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Онцгой комисс 3 удаа хуралдан 12 асуудлыг хэлэлцэж 24 асуудлыг шийдвэрлэн аймгийн Засаг даргын захирамж 4, тогтоол 1, хурлын тэмдэглэл 3-г гарган албажуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын тогтоол, тушаал шийдвэрийн дагуу аймгийн Онцгой комиссын хуралдаанаас гарсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах чиглэлээр сум, агентлаг, аж ахуй, нэгж, байгууллагуудад нийт 56 албан тоотгоор үүрэг чиглэл, зөвлөмж, шаардлага, хүсэлтийг хүргүүлж, 32 албан бичгийн бүртгэл хөтлөн хүлээн авч, албан бичгээр ирсэн тайлан мэдээг боловсруулан нэгтгэж, өдөр тутмын нөхцөл байдлын мэдээнд тусгуулах, ирсэн хүсэлтийг холбогдох ажлын хэсэгт хүргэн шийдвэрлүүлэн ажиллаж

Шуурхай штабын 70363684, 70360119 дугаарын утсанд 344 мэдээлэл, цахим хаягаар 142 албан бичиг, гар өргөдөл 12 нийт 498 мэдээллийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас болон Онцгой байдлын газрын цахим пэйж хуудсанд Онцгой байдлын газар, “Дэлхийн Зөн Монгол” Олон Улсын байгууллагатай хамтран “Яагаад амны хаалт зүүх ёстой вэ?”, “Гараа яагаад угаах ёстой вэ?”, “Хамтын хүчээр халдвараас сэргийлье”, “Ковидгүй Сэлэнгийн төлөө” “Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулсан сэрэмжлүүлэг шторк 5-ыг бэлтгэн, 104 удаа мэдээ, мэдээлэл байршуулж 128,252 хандалтыг авч Онцгой комиссын орлогч, Шуурхай штабын дарга, дэд хурандаа Г.Галбадрах цаг үеийн нөхцөл байдал, хариу арга хэмжээний талаар “Сэлэнгийн мэдээ” сонинд ярилцлага өгсөн. Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран 2021 оны 03 сарын 01-ний өдрөөс эхлэн өдөрт 2 удаагийн давтамжтайгаар 12:00, 17:00 цагуудад нөхцөл байдлын талаарх мэдээлэл бэлтгэн аймгийн Засаг даргын Тамгын газраас “Сэлэнгэ аймаг АЗДТГ”, “Сэлэнгэ Цахим телевиз” цахим хуудас, Зиндаа.мн сайт, Улс төрч.мн сайт, Сүхбаатар сум дахь лед дэлгэц, орон нутгийн “Миний Монгол ТВ”, “Таны Сэлэнгэ ТВ” мөн МҮОНТ-ийн ММ агентлаг, Өлзий телевиз, Монцамэ агентлаг зэрэг мэдээллийн сувгуудаар мэдээ, мэдээллийг дамжуулан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Онцгой комиссын шуурхай штаб, Онцгой байдлын ерөнхий газарт тухай бүр мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын 1 дүгээр давлагаанд **217**, 2 дугаар давлагаанд **10729** нийт **10946** тохиолдолд батлагдаж 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар **7755** иргэн эдгэрч, **29** хүн нас барж, 13 ковидын эмчилгээний тасагт **388** иргэн хэвтэн эмчлүүлж, гэрийн эмчилгээнд **1960** иргэн өрх болон сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн хяналтад байна.

Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нэгдүгээр тун **61385**, хоёрдугаар тун **54700** хийгдээд байна.

23 хяналтын цэгт давхардсан тоогоор Цагдаагийн газрын 600 албан хаагч 23 тээврийн хэрэгсэлтэй, Онцгой байдлын газрын 900 алба хаагч, Эрүүл мэндийн байгууллагын 1470, Мэргэжлийн хяналтын газрын 30 бусад төрийн байгууллагуудтай хамтран нийт 3000 албан хаагч үүрэг гүйцэтгэсэн.

Аймгийн хэмжээнд **2105** цэг байршилд **980046.2** м2 талбайд урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн хэмжээнд шатахуун тээвэрлэлт орох чиглэлд 25, гарах чиглэлд 24, хүнс тээвэрлэлт орох чиглэлд 3, гарах чиглэлд 3, малын өвс тэжээл, үр тариа орох чиглэлд

39, гарах чиглэлд 29 тээврийн хэрэгсэл хөдөлгөөн үйлдсэн байна.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд мал амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний дуудлага 1, объектын гал түймэр 6 удаагийн дуудлагаар тус тус гарч ажилласан.

08 сарын 30-ны өдөр Мандал суманд Шүлхий өвчний сэжигтэй тохиолдол илэрч 2021 оны 09 дүгээр 01-ний өдрийн 21-3611, 21-3612 дугаартай шинжилгээний дүнгээр “шүлхий” өвчнөөр өвчилсөн болох нь тогтоогдсон.

Голомтын болон сэжигтэй бүсийн 8 айл өрхийн малын хашаа, өвчтэй малын бэлчээр болон тоног хэрэгслийг тусгай зориулалтын ариутгалын ДУК автомашинаар нийт 285962 м2 талбайд ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийсэн.

Вакцинжуулалтад нийт төлөвлөсөн эрүүл, хамгаалалтын, сэжигтэй болон голомтын бүсийн мал, амьтнаас 119896 мал буюу 100 хувийг хамруулаад байна.

Объектын гал түймэр нийт 6 удаа гарч 500.0 төгрөгийн хохирол учирч мөн иргэн, аж ахуй нэгжийн 510.000.0 төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан.

Монгол Улсын Шадар сайдын баталсан боловсролын байгууллагуудын Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлыг биелэлтийн хяналт шалгалтын хүрээнд аймгийн хэмжээнд 39 объектод хяналт шалгалт зохион байгуулж, 141 зөрчил дутагдлыг илрүүлж, хяналт шалгалтын явцад 80 зөрчлийг арилгуулж, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 21 мэдэгдэл, 6 дүгнэлт, заавал биелүүлэх 4 албан шаардлагын холбогдох иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлсэн.

Ус цаг уур орчны шинжилгээний газраас ирүүлсэн 4 цаг агаарын урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээний дагуу Онцгой байдлын газрын цахим хуудсанд цаг агаарын 6 сэрэмжлүүлэг мэдээллийг байршуулж иргэдэд хүргэж ажилласан.

Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх танхимын сургалтыг 1 эмнэлгийн байгууллагын 8 ажилтан алба хаагч нарт 2 цагийн хугацаатайгаар зохион байгуулсан.

Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:

Аймгийн хэмжээнд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг 09 дүгээр сарын байдлаар худалдаа үйлчилгээний 559 аж ахуй, нэгж, 3732 албан байгууллагад 2052391.5 м2 талбайд Зооноз өвчин судлалын төв, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг голомтын халдваргүйжүүлэлтийг хийхэд хяналт тавьж ажиллалаа.

2021-2022 оны хичээлийн жилд төрийн өмчийн 34, хувийн 1, нийт 35 ерөнхий боловсролын сургуулийн 802 бүлэгт 22002 суралцагчид 1898 багш ажилтнууд боловсролын үйлчилгээг, сургуулийн өмнөх боловсролын төрийн өмчийн 39, хувийн хэвшлийн 2, байгууллагын дэргэдэх 3 нийт 44 цэцэрлэгийн 275 бүлэгт 6727 хүүхдэд 1254 багш ажилтнууд боловсролын үйлчилгээг, Халдварын түвшингээр улбар шар түвшинд буй Сүхбаатар сумын 7 ЕБС, Мандал сумын /Хэрх, Түнхэл/ ЕБС 7 тус 2 сумын нийт 14 ЕБС байгууллагууд танхимын болон цахим хосолсон сургалтын хэлбэрээр, шар түвшинд буй бусад сумдын 21 ЕБС, 44 СӨБ байгууллагууд танхимаар хичээллэж байна. 09 дүгээр сарын байдлаар ковид батлагдсан удирдах ажилтан нийт 24 үйлчилгээний туслах ажилтан нийт 117 Багш нийт 225 хүүхэд нийт 361 ажиллагсад халдвар авсан байна.

Стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:

Мандал, Сүхбаатар, Цагааннуур, Сайхан, Сант, Баянгол сумын 35 аж ахуйн нэгжийн 36 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, МУ-ын “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ, Ерөнхий шаардлага MNS 5021-1:2019”, “Хоолны газрын үйлчилгээ, Ерөнхий шаардлага MNS 4946:2019”, “Үс засах үйлчилгээнд тавих

шаардлага MNS 5021-1:2019” стандартын шаардлага хангасан 35 иргэн, аж ахуйн нэгжийн 36 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олгосон.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 7 аж ахуй нэгж, байгууллага, иргэний захиалгын дагуу 3 нэрийн 8 стандартын талаар мэдээлэл арга зүйн зөвлөмж өгч, 3 нэрийн 8 стандарт борлуулж, албан хэрэгцээнд 2 нэрийн 2 стандарт олгосон байна.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: Мандал сумын 13 шатахуун түгээх станц, 1 АХЦС-ын нийт 43 хэмжих хэрэгсэлд ээлжит баталгаажуулалт хийсэн.

Механикийн хэмжлийн төрлөөр: Мандал сум, Түнхэл тосгоны эмнэлгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа 38 ш цусны даралтын аппарат, 15ш эмнэлгийн жинг ээлжит шалгалт баталгаажуулалтад хамруулав. Баянгол, Мандал сумын 70 гаруй жин, туухайг ээлжит баталгаажуулалтад хамруулсан.

Дулаан даралтын хэмжлийн төрлөөр: Мандал сум, Түнхэл тосгоны эмнэлгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа 38 ширхэг цусны даралтын аппарат, шалган баталгаажуулав.

Цахилгаан хэмжлийн төрлөөр: Айл өрх, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй 1 фазын 15 ширхэг цахилгааныг тоолуурыг шалган баталгаажуулсан.

Мандал сумын “СББ” ХХК-ий автомашины 2 жин, Улсын нөөцийн сангийн 1 авто жинг шалгалт баталгаажуулалтад “СББ” ХХК-ий сорилт шинжилгээний лабораторийн нийт 49 хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийлээ.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Өнгөрсөн сард 716 баримтаар 9,137,043.2 мянган төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 08 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн web сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

2022 оны төсвийн төслийг Сангийн ямаар батлуулахаар хуваарийн дагуу сумд болон байгууллагуудын төслийг хянуулж ажиллалаа.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		73,647,554.2	75,618,783.1	102.7
1.1	Орон нутгийн төсвийн орлого	16,822,664.9	21,615,848.8	127.4
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	11,822,664.9	13,283,833.2	112.4
	Сумдын төсвийн орлого	5,144,638.1	8,332,015.6	162.0
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	3,214,788.8	3,214,788.8	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	36,627,384.1	36,627,384.1	100.0
1.4	Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг	437,571.2	266,908.5	61.0
1.5	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	5,501,633.1	5,873,388.4	106.8
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	5,166,044.4	5,166,044.4	100.0

1.7	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	1,659,256.3	1,659,256.3	100.0
1.8	Төсөвт байгууллагын өөрийн орлого	155,664.1	194,353.3	124.9
1.9	ОНХС-д хандив	1,910,000.0		
1.10	Сум хөгжүүлэх сан /орлого/	2,007,909.2	1,000,810.4	49.8
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		73,647,554.2	56,206,616.3	76.3
Орон нутгийн төсвийн нийт зарлага		73,647,554.2	56,206,616.3	76.3
Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага		17,644,666.1	11,921,569.7	67.6
Сумдын орон нутгийн хөгжлийн сан		3,699,009.2	1,341,141.3	36.3
Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага		10,943,900.9	6,586,619.3	60.2
Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт		569,070.0	78,357.6	13.8
2.1	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	4,400,501.6	1,459,834.6	33.2
Халамжийн сан		115,339.4	52,400.0	45.4
Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага		4,807,057.6	4,170,826.6	86.8
Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө		1,051,932.3	825,200.4	78.4
Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага		40,699,047.8	35,748,225.3	87.8
Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага		660,930.2	609,060.8	92.2
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		51,454,143.4	51,825,898.7	100.7
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	9,325,126.2	8,014,732.9	100.0
Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		2,583,174.7	1,889,413.5	100.0
3.2	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	94,228.0	94,228.0	100.0
Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд				
Хөрөнгө оруулалтын зардалд		2,488,946.7	2,488,946.7	100.0
Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг		2,918,458.4	3,290,213.7	112.7
3.3	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	2,577,307.8	2,577,307.8	100.0
Усны татаас		319,500.0	319,500.0	100.0
Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд		21,650.6	21,650.6	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	36,004,065.2	36,004,065.2	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	623,318.9	623,318.9	100.0
Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/		36,627,384.1	36,627,384.1	100.0
3.6	- Ерөнхий боловсролын сургууль	19,612,317.2	19,612,317.2	100.0
- Хүүхдийн цэцэрлэг		10,074,606.2	10,074,606.2	100.0
- Эрүүл мэндийн байгууллага		6,219,235.2	6,219,235.2	100.0
- Газрын кадастрын байгууллага		375,784.3	375,784.3	100.0
- Хүүхдийн байгууллага		345,441.2	345,441.2	100.0
4. Тусгай сангуудын зарлага		2,007,909.2	1,000,810.4	49.8
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	2,007,909.2	1,000,810.4	49.8

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөнхэрэглээний барааны нэртөрөл		2020 08- сар	2021 08- сар	2021-08 2020-08 Х/төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 200	1 650	137.5
	Талх /орон нутгийн, ш/	1 300	1 300	100.0
	Нарийн боов /кг/	2 600	4 000	153.8
	Будаа /кг/	2 600	2 700	103.8
	Элсэн чихэр /кг/	2 000	2 400	120.0
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	7 500	8500	113.3
	Үхрийн мах /кг/	8 500	9 500	111.8
	Адууны мах /кг/	7000	7500	107.1
	Ямааны мах /кг/	6800	7 500	110.3
	Дотор мах, цувдай /цусгүй/	4500	5 000	111.1
	Хиам /чанасан, кг/	11 000	12 500	113.6
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	800	1 200	150.0
	Сүү / савласан, л/	3 200	3200	100.0
	Тараг /задгай, л/	1 000	1 300	130.0
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	16 000	21 000	131.3
	Айраг /л/	4 000	5 000	125.0
	Хуурай сүү /кг, Орос, 25 хувь тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	4 500	5 300	117.8
	Өөхөн тос /кг/	2 500	2800	112.0
	Шар тос /кг/	15 000	20 000	133.3
	Масло /задгай, кг/	4 500	4 700	104.4
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	2 500	3 000	120.0
	Лууван /кг/	2500	2 800	112.0
	Манжин /кг/	3000	3500	116.7
	Байцаа /кг/	1500	2800	186.7
	Сонгино /кг/	2000	3400	170.0
	Өргөстхэмх /шилтэй, дарсан/	4 500	5 500	122.2
	Алагсалат /шилтэй, Urbanek, 630гр/	3000	4 700	156.7
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 370	2040	148.9
	Бензин А - 92	1420	2070	145.8
	Дизелийн түлш	1990	2490	125.1

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/173 дугаар тушаал, мөн тушаалаар батлагдсан төрийн архивын үйл ажиллагаанд улсын үзлэг явуулах удирдамжийн дагуу Архивын ерөнхий газрын Мэдээллийн технологийн газрын дарга, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын ахлах байцаагч Х.Төмөрбаатар, Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар, Мэргэжил, арга зүйн удирдлагын

газрын ахлах байцаагч Ц.Золжаргал нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Төрийн архивын тасгийн үйл ажиллагааг төрийн архивын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, төрийн архивын баримтын хадгалалт хамгаалалт, төрийн архивын цахим сан бүрдүүлэлт чиглэлийн 16 үзүүлэлтээр шалган дүгнэсэн.

Ардын хувьсгалын 100, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг угтан Сэлэнгэ аймгийн түүхэнд холбогдох баримтуудыг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд Сүхбаатарын туг сонины баримтуудыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг хийж эхлүүлээд байна.

Архивын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын төлөвлөгөөг 5 өдрөөр гаргаж гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын лавлагаа нийт 157 гаргаж үйлчилснээс цахимаар 136, мастер хувиас 13, цаасан суурьтай баримтаас 8 лавлагаа, магадалгаа, тодорхойлолт 25, малын А дансны хуулбар 3-ыг тус тус гаргаж үйлчилсэн байна.



Цагдаагийн газар: Аймгийн хэмжээнд 2021 оны эхний 09 дүгээр сард 321 холбогдогчтой 2724.2 сая төгрөгийн хохиролтой 497 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 31 хэргээр буюу 6.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 44.2 хувьтай байгаа нь өмнө оныхоос 5.3 хувиар буурсан байна.

Улсын бүртгэлийн хэлтэс: Иргэний бүртгэлийн талаар:

- Төрсний бүртгэл - 118 /эрэгтэй-64, эмэгтэй-54/
- Гэрлэлтийн бүртгэл - 20
- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 4
- Үрчлэлт - 4
- Эцэг тогтоолт - 3
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 4
- Нас баралт - 50
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 244
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 79
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 37
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусч солиулсан - 128
- Гадаад паспорт олголт - 16
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 39
- Хот доторх шилжилт хөдөлгөөн - 78 тус тус бүртгэгдсэн байна.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

Боловсрол, соёл урлаг, спортын талаар: Ерөнхий боловсролын 11 сургууль танхимаар, 19 сургууль 5/9-ийн зарчмаар танхим, цахим хосолсон хэлбэрээр, 5 сургууль цахимаар, цэцэрлэгүүдээс 2 цэцэрлэг цахимаар хичээллэж, коронавирусын халдвараар өвдсөн багш, сурагч, удирдах ажилтан, бусад ажилтны мэдээллийг өдөр бүр авч, нэгтгэн ажиллаж байна.



2020-2021 оны хичээлийн жилд элсэлтийн ерөнхий шалгалтаа амжилттай өгч аймагтаа манлайлсан 13 сурагч, дундаж оноогоор сурагчид нь хамгийн өндөр авсан 6 багшид УИХ-ын гишүүн Ч.Ундрэм “Чинбатын Ундрэм хөгжлийн сан”-гийн нэрэмжит тэтгэлгийг олгосон.

Боловсрол, Шинжлэх ухааны дэд сайд болон газрын дарга нар 09 Шаамар, Ерөө сумдад ажиллаж, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын ажилтай танилцлаа.

Сурагчдын сурлагын хоцрогдлын шалтгаан, нөхцөл байдлыг илрүүлэх зорилгоор Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулж байгаа “Оношлох үнэлгээ”-нд 32 сургуулийн 2-12 дугаар ангийн 6577 суралцагчийг түүврийн аргаар сонгон, шалгалтыг авлаа. Тус төвөөс томилогдсон 1 зохион байгуулагч, Боловсролын газрын даргын тушаалаар томилогдсон 32 зохион байгуулагч сургуулиуд дээр ажиллаж байна.

2021-2022 оны хичээлийн жилд 44 цэцэрлэг сургалтын үйл ажиллагааг зохион явуулж байгаагаас төрийн өмчийн 1 Сүхбаатар сумын 8-р цэцэрлэг шинээр ашиглалтад ороод байна.

Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэгдэн гарсан Боловсрол, Шинжлэх ухаан, Эрүүл мэндийн сайдын А/292, А/525 тоот тушаалаар батлагдсан түр журмыг баримтлан тулгач буй асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Цэцэрлэгт танхимын сургалтад хамтрагдаж байгаа 4,5 настай хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний хуваарийг Сүхбаатар сумын 9 цэцэрлэгт гарган 700 гаруй хүүхдийг хамруулсан. Бусад 35 цэцэрлэгүүд сумын эрүүл мэндийн төвтэйгээ хамтран хүүхдийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулан ажилласан.

Хичээлийн шинэ жил эхлэж буйтай холбоотой “Дэлхийн зөн Монгол” ОУБ Сэлэнгэ орон нутгийн хөтөлбөр 35 сургууль, 44 цэцэрлэгт нийт 11.720.948 төгрөгийн 73 санитол, 71 халуун хэмжигчийг өгч, ковидоос урьдчилан сэргийлэхэд хувь нэмэр орууллаа.

2021 оны Дэлхийн багш нарын баярыг тохиолдуулан шагналд нэр дэвшигчдын материалыг яамны Шагналын системээр болон цаасаар хүлээн авч бүртгэл хийн хүсэлтийг уламжилсан.

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэгт ерөнхий боловсролын сургуулийн 84 багш ажилчдад 383,2 сая төгрөг, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 40 багш, ажилтанд 178,4 сая төгрөгийг анхан шатны баримтыг үндэслэн олгосон.

Өндөр насны тэтгэвэрт гарахад нь олгодог нэг удаагийн тэтгэмжийг ерөнхий боловсролын сургуулийн 14 багш ажилтанд 182,6 сая төгрөг, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 2 багш ажилтанд 28,6 сая төгрөгийг тус тус олгосон байна.

БШУЯ-ны сайдын 2021 оны А/279 тоот “Ариутгалын зардал батлах тухай” тушаалаар батлагдсан хуваарийн дагуу аймгийн төрийн өмчийн 34 сургуулийн хичээлийн байранд 7.814.400 төгрөг, 20 дотуур байранд 2.816.000 төгрөг, мөн төрийн

өмчийн 39 цэцэрлэгт 8.393.600 төгрөгийг мэргэжлийн байгууллагаар ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэхэд зориулан нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан санхүүжилтийг 100 хувь хийж хүргүүлсэн.

БШУЯ-наас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 72 нэр төрлийн 64,9 сая төгрөгийн сурах бичиг, журнал ирснийг манай газарт хуваарилалтыг хийж аймгийн нийт сургуулиудад цаг тухайн бүрт тараалтыг хийж холбогдох баримтын хамт хүргүүлэн ажиллаж байна.

Спорт сургууль 1-5 дугаар анги шинээр нээгдсэнтэй холбоотой үдийн цайны тоног төхөөрөмж шинээр шаардлагатай болж БШУЯ-нд хандсанаар 16,7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг хийсэн.

Эрүүл мэндийн талаар: 09 дүгээр сарын байдлаар Ковидын 14 тасагт байгаа нийт 429 хүнээс биеийн байдал хөнгөн 332, хүндэвтэр 76, хүнд 21, нэн хүнд-0, Жирэмсэн-32, 0-17 насны 48 хүүхэд байна. Нийт 6580 иргэн /Эдгэрэлт-45/ эмчлэгдэж гарсан байна. Эмнэлэгт хэвтсэн 44. Гэрээр аймгийн хэмжээнд 17 сум, тосгонд 2117 иргэнийг өрх болон сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн хяналтад эмчилж байна. Нийтдээ Ковид-19 халдварыг илрүүлэх түргэвчилсэн оношлуураар шинжилгээнд Сүхбаатар сум хамрагдсан дүн 25516 үүнээс 1129 эерэг, сумдууд 96985 үүнээс 5346 эерэг түргэвчилсэн оношлуураар шинжилгээнд хамрагдсан нийт дүн 122501 үүнээс 6475 байна. Эрсдэлт бүлэг, сайн дурын хавьтлын 138 ПГУ шинжилгээ хийгдэж байгаа, бөгөөд өссөн дүнгээр нийт 89982 шинжилгээ байна. Сүхбаатар сумын суурин цэг 2, Алтанбулаг хилийн боомт, явуулын цэг 3, 25 сум, тосгонд шинжилгээний баг ажиллаж түргэвчилсэн шинжилгээ авч нийт 31 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 17 сум 6 тосгонд голомт хэлбэрээр гарсан бөгөөд нийт 10640 ойрын хавьтал, 4937 дам хавьтлыг гэрээр тусгаарлан ажиглаж, хяналт тавин ажиллаж байна.

Сүхбаатар суман дахь “Коронавирусын халдвар батлагдсан иргэдийн гэрийн эмчилгээ хяналт” Дулаанхаан тосгоны ЭМТ-тэй хамтран 2 хүний бүрэлдэхүүнтэй 4 баг гаргаж нийт 387 иргэнд гэрээр үзлэг хийж, гэрийн эмчилгээний багц олгосон байна. Коронавируст халдварын талаар зөвлөгөө мэдээлэл өгөх дуудлагын утсыг 24 цагаар ажиллуулж байна.

“Сорьц авах дараалал, хадгалалт, тээвэрлэлт” сэдвээр сургалт Гааль, Хилийн цэргийн 101 дүгээр анги, Хилийн мэргэжлийн хяналтын албаны эмч нарт /Ковид-19/-ийг илрүүлэх шинжилгээ авах аргачлал, дараалал, сорьц хадгалалт, тээвэрлэх үеийн технологи ажиллагааны талаар сургалтыг зохион байгууллаа.

“Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах нь” сэдэвт сургалт Монголын сумын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн холбооноос “Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах нь” сэдэвт сургагч багш бэлтгэх 3 хоногийн сургалтад 2 мэргэжилтэн хамрагдсан.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх, халамжийн шинэ үйлчилгээг нэвтрүүлэхэд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор 17 сум 6 тосгонд мэргэшиж, дадлагажсан 35 мэргэжилтнүүдээр төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Улсын төсвийн орлогоос: Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 34073 иргэнд 13529676.5 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

1. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2350 иргэнд 5976688.7 мянган төгрөг
2. Нийгмийн халамжийн тэтгэмжид 1835 иргэнд 1297802.9 мянган төгрөг

3. Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1741 иргэнд 903255.1 мянган төгрөг
4. Жирэмсэн эхийн тэтгэмжид 1086 эхэд 264703.1 мянган төгрөг
5. 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 5079 эхэд 2143927.6 мянган төгрөг
6. Ихэр хүүхдийн тэтгэмжид 17 иргэнд 34000.0 мянган төгрөг
7. Эхийн алдар одонгийн тэтгэмжид 8851 иргэнд 1174400.0 мянган төгрөг
8. Насны хишиг тэтгэмжид 5121 иргэнд 804700.0 мянган төгрөг
9. Өрх толгойлсоны тэтгэмж 256 иргэнд 293965.7 мянган төгрөг
10. Ахмадын настанд олгох хөнгөлөлт, тусламжид 2004 ахмадын 129144.3 мянган төгрөг
11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжид 306 иргэний 75512.8 мянган төгрөг
12. Хүнсний эрхийн бичгийн 5427 иргэнд 431575.9 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

Орон нутгийн төсвийн орлогоос: Халамжийн санд орон нутгийн төсвөөс тайлант хугацаанд 52 иргэнд 51200.0 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

1. Орон гэрийн хөнгөлөлт, тусламжид 24 иргэнд 28800.0 мянган төгрөг
2. ОНОТХҮ төсөлд 28 иргэнд 22400.0 мянган төгрөгийг зарцууллаа.

08 дугаар сарын 25-ны байдлаар бүртгэлтэй ажил хайгч 564 байсан бол 317 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 120 ажлын байранд 100 хүнийг ажилд зуучилж, идэвхгүйн улмаас 84 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 697 болсон байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 452000.0 мянган төгрөгийн санхүүжилт, Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр 15315.0 санхүүжилт орж ирсэн. Мөн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 276 иргэний 331379.3 мянган төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр 4 байгууллагын 34020.0 мянган төгрөг орж ирсэн байна.

Зарлагын талаар:

№	Хөтөлбөрийн нэр	2021 оны эхний үлдэгдэл	Энэ онд шинээр нэмэгдсэн	Эргэн төлөлт хийсэн дүн	Эцсийн үлдэгдэл
1	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	356,238,385	124,000,000	108,794,175	371,444,210
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	63,972,960	26,000,000	28,770,395	61,202,565
3	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	399,248,610	84,000,000	156,784,230	326,464,380
4	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	27,788,500	27,000,000	11,060,000	43,728,500
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	152,463,075		25,970,475	126,492,600
6	Нийт дүн	999,711,530	261,000,000	331,379,275	929,332,255

Эргэн төлөлт төвлөрүүлэлт: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв санд санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт болох 324765.6 мянган төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр 34020.0 мянган төгрөг нийт 358785.6 мянган төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар: Хүүхэд залуусын номын хэрэглээг нэмэгдүүлэх, нийгмийн харилцаа холбоог номоор дамжуулан эзэмшүүлэх зорилгоор “Хүслийн хөтөч” хүүхэд хамгаалал, оролцооны клуб хамтран “Ном солилцоо” өдөрлөг зохион байгуулж, 154 оролцогч оролцож, 402 ном хүлээн авч, 336 ном хүлээлгэн өгсөн.

“Хүслийн хөтөч” хүүхэд хамгаалал, оролцооны клубын гишүүд шинээр элсэгчидтэй мэдлэг туршлагаа солилцон, үйл ажиллагаа зохион байгуулах арга, ур чадварын талаар зөвлөгөө өгч, их, дээд сургуульд элсэн орсон гишүүдээ үдэх зорилгоор Дэлхийн-Зөн Монгол ОУБ-ын Зүүнхараа ОНХ-тэй хамтран “THANK AND WELCOME” арга хэмжээг зохион байгуулж, нийт 30 оролцогч оролцолоо.

Коронавируст цар тахлын үед өсвөр насны хүүхдүүдэд тулгамдаж буй асуудлыг хөндөн, түүнийг шийдвэрлэх, нийгмийн харилцаанд эргэн нэгдэхэд шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх зорилгоор “BACK TO SCHOOL” урьдчилан сэргийлэх цахим сургалтыг Мандал, Сайхан, Баянгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн 470 сурагчдыг хамруулан зохион байгуулав.

Тус арга хэмжээг дараах 4 дэд сэдвийн хүрээнд өрнүүлж, хүүхдийн үзэл бодлыг сонсон түүнд тулгуурлан хэрэгтэй, үр дүнтэй зөвлөгөө өгч чадлаа.

- Дэлгэцийн донтолт
- Харилцаа хандлага
- Өөртөө итгэх итгэл
- Бүтээлч байдал

Зүүнхараа Хүүхдийн ордны шатар, төгөлдөр хуур, англи хэл, уран зураг, бүжгийн цахим сургалтад нийт 43 хүүхэд хамрагдсан байна.

Ядуурлыг бууруулах Японы сангаас санхүүжиж Азийн Хөгжлийн Банкны бодлого журмын дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хэрэгжүүлж буй “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг дэмжих” төслийн Сэлэнгэ аймаг дахь ажлын хэсэгт ажиллалаа. Уг төслийн хүрээнд аймгийн хэмжээнд 30 эмэгтэйн ахуй амьдралтай танилцаж, эхний шатанд тэнцсэн 26 эмэгтэйн холбогдох материалыг бүрдүүлэн “ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТӨСӨЛ, G9198MON”-д хүргүүлсэн.

Хүүхдийн тоглоомын талбай Ерөнхий шаардлага MNS6751:2019 стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор хүүхдийн тоглоомын талбайн судалгаа авч нэгтгэхэд нийт 175 хүүхдийн тоглоомын талбай байгаагаас эзэмшлийн хувьд: төрийн байгууллагын харьяа 65, төрийн бус байгууллагын харьяа 20, стандарт шаардлагын хувьд солих шинэчлэх шаардлагатай 15, огт тоглоом байдаггүй 5, 1-3 ширхэг тоглоомтой 33, 8-аас дээш тоглоомтой 6 байна. Дээрх тоон үзүүлэлтийг харахад 1-12 насны хүүхдийн хэрэгцээг хангаж чадахгүй байгаа 31 тоглоомын талбай байна.

Хүүхдийн тоглоомын талбайг байгуулахдаа байгалийн хүчин зүйлст нэрвэгдэхээс урьдчилан тооцож мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг сумдын сургууль, цэцэрлэгүүдэд хүргүүлэн ажиллалаа.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Мал эмнэлгийн үйлчилгээний талаар: Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын 225-р тогтоолын дагуу төлөвлөгөөт вакцинжуулалтыг технологит

хугацаанд давхардсан тоогоор 11 нэр төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд энэ онд нийт 1241.4 мян.тол мал амьтан хамруулахаас энэ сард 132.2 мянган толгой мал, амьтан буюу 16.4 хувийг хамруулсан. Аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 132200 толгой малыг сүргийн эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.

Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч нар 186 өрхөд технологийн, 196 өрхөд гүйцэтгэлийн нийтдээ 265 өрхийн дархлаажуулалтын арга хэмжээнд хяналт тавьж ажиллалаа.

Хүнсэнд 1635 гэрчилгээгээр адуу 63, үхэр 825, хонь 7365, ямаа 1852, гахай 18, толгой буюу нийт **10123** толгой мал, амьтан, 89562 кг мах, махан бүтээгдэхүүн, 256342 л сүү, сүүн бүтээгдэхүүн, 48658 арьс шир, түүхий эд буюу нийт 235441 кг, ширхэг бүтээгдэхүүн, **536** гэрчилгээгээр адуу 536, үхэр 1685, хонь 568, ямаа 485, гахай 25, толгой буюу нийт 3299 толгой мал, амьтан шилжилт хөдөлгөөн хийсэн байна.

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж байгаа мах махан бүтээгдэхүүний 8024 кг үхрийн махны 71 дээж, 2436 кг хонины махны 169 дээж, 1212 кг ямааны 93 дээж, сүү, сүүн бүтээгдэхүүний 110 л сүүний 3 дээж, 310 л тарагны 5 дээжинд ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн.

Цагааннуур, Зүүнбүрэн, Түшиг, Баянгол, Мандал, Баруунбүрэн, Жавхлант, 391 бух, 2920 үнээ, 923 хуц, 243 ухна, нийт 3647 дээжинд ийлдэс судлалын шинжилгээг хийж халдварлалтгүй болохыг тогтоож хариуг мал эмнэлгийн газрын дарга, ерөнхий эмчээр баталгаажуулан малчин, мал бүхий иргэнд, хүргүүлж цахим системд бүртгэсэн.

Сэжигтэй голомтод ажиллаж буй 2 малын эмч нийт 8 өрхийн 300 толгой үхэрт үзлэг хийхэд одоогийн 60 толгой үхэрт шинж тэмдэг илрээд байгаа бөгөөд биеийн байдал хүнд үхэр байхгүй байна. 8 өрхийн бэлчээр болон малын хашаа саравчид давхардсан тоогоор 24 удаагийн ариутгал халдваргүйтгэл хийсэн. Одоогоор голомтын 8 өрхийн 367 толгой үхрийг үзлэг хийж 60 толгой үхрийг тусгаарлаж, ариутгал халдваргүйжүүлэлтийг голомтын 8 өрхийн 3500 м2 талбайд хийгээд байна.

Хөдөө аж ахуйн талаар: Аймгийн хэмжээнд хаврын тариалалтад үр тарианы 304 аж ахуй нэгж, 199 иргэн, төмс, хүнсний ногооны 33 аж ахуйн нэгж, 2251 иргэн 209 мянган га талбайд тариалалт хийсэн.

09 дүгээр байдлаар улаанбуудай ангилсан 15103 га талбай, цайруулсан 1266 га талбайгаас 2320 тн, шууд хураалт 5014 га талбайгаас 6697 тн, овьёос 141 га талбайгаас 227 тн, тэжээлийн ургамал 230 га талбайгаас 250 тн, тосны ургамал ангилсан 6014 га талбай, шууд хураалт 3760 га талбайгаас 3071 тн, төмс 986 га талбайгаас 10378 тн, хүнсний ногоо 1182 га талбайгаас 14150 тн хураасан байна.

Байгаль цаг уурын техникийн хүчин чадлаас хамааран намрын ургац хураалтыг үтрэмээс гурилын үйлдвэрт буудай нийлүүлэх талбай чөлөөлөх технологийн хугацаа 7-10 хоногийг оруулан тооцоход ургацыг 24-28 хоногт багтаан хураах техникийн тооцоо гарч байна. Хаврын тариалалтын үеийн чийг, хугацаа, гол хатгалтын үе болон хэт борооны улмаас таримлын болц харьцангуй жигд бус байсан. 12 аж ахуйн нэгж ангилан хадгалт хийж эхэлсэн.

2021 оны улаанбуудайн үрийн нөөц бүрдүүлэх зорилгоор 7 сумын 20 аж ахуйн нэгжид 10000 га талбайд сортын хянан баталгаа хийж, хянан баталгааны дүнг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэн ажиллалаа.

08 дугаар сарын 18-22 нд орсон борооны улмаас Сэлэнгэ мөрөн үерлэж олон жилийн дунджаас 114 см-ээр нэмэгдэн зорчих хөдөлгөөн хаагдаж, намрын ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн ажилд хүндрэл үүсэж, Цагааннуур суманд төмс,

хүнсний ногооны 15 га, улаанбуудайн 34 га, тэжээлийн 10 га, тосны 10 га, Зүүнбүрэн сумын 31 өрхийн 7 га төмс, 65 га хүнсний ногоо үерт автсанаас 3 тн ногоог нүүлгэн шилжүүлсэн. Зүүнбүрэн сумын 15 өвөлжөө 600 га хадлангийн талбай, Хушаат сумын 3 аж ахуйн нэгжийн 240 га тариалангийн талбай, төмс, хүнсний ногооны 62 га талбай, 5 өвөлжөө хадлангийн 500 га талбай үерт автсанд холбогдох арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас үерийн нөхцөлд ажиллах моторт завины моторын асуудлыг шийдвэрлэн 4,5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Аймаг сумын Онцгой комисмтой хамтран ажилласны үр дүнд үерт боогдсон малчид, ногоочдыг хохирол багатайгаар нүүлгэн шилжүүлсэн.

Аймгийн хэмжээнд 99 мян.га талбайд уринш хийснээс механик аргаар 40 мян.га талбай, хосолсон аргаар 59 мян.га талбайд хийгдсэн.

Мөн намрын ургац хураалтад 411 комбайн, 125 будаа цэвэрлэгч, 128 будаа ачигч, 10 төмсний комбайн, 5 даршны комбайн, 27 төмс ухагч, 32 хүнсний ногоо хураагч, 22 механикжсан үтрэм ажиллахад техник засвар үйлчилгээний ажил хийгдэж байна. Техникийн бэлэн байдал 96.1хувьтай явагдаж байна.

Аймгийн хэмжээнд 59 аж ахуй нэгж, иргэдийн 143 оюутан, 512 цэрэг, 27 гэрээт нийт 697 ажилтны захиалгыг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлээд байна.

Төмс, хүнсний ногоо тариалагч иргэд 7 сарын 15-аас эхлэн эрт ургацын ногоог зах зээлд гарган Улаанбаатар хотын Чингэлтэй, Баянзүрх, Баянгол, Хан-Уул дүүргүүдийн 21 цэг байршилд 80 гаруй ногоочид худалдаа эрхэлж, 540 тн төмс, 1090 тн хүнсний ногоог худалдан борлуулсан байна. Төмс хүнсний ногооны хураалт 22,3 хувьтай явагдаж байна.

Аймгийн хэмжээнд төмс, хүнсний ногоо хадгалах зориулалт бүхий 34.1 мян.тн-ы багтаамжтай зорьтой. Энэ нь тухайн жилийн хураан авсан ургацын 28 хувийг хадгалах боломжтой байна.

“Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2021” нэгдсэн арга хэмжээ Улаанбаатар хотод зохион байгуулагдаж, үзэсгэлэн худалдаанд 31 ногоочин, 2 хоршоо оролцож төмс 20 тн, 11 төрлийн хүнсний ногоо 60 тн, даршилсан ногоо 1000 шил, зөгийн бал 350 шилийг худалдан борлуулж нийт 116,5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.

Борлуулалт, бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ тэргүүлсэн аж ахуйн нэгж шилдэгээр тодорсон. Үүнд:

❖ **Газар тариалангийн салбарын шилдгээр:**

- Сүхбаатар сумын иргэн Д.Сосорбарам (Ил талбайн шинэ сортын хүнсний ногоо тариалж нутагшуулсан ногоочин)
- Питомник ХХК-ий захирал Х.Сарангэрэл (Шилдэг жимс жимсгэнийн суулгац үржүүлэгч)
- Ургац Ерөө хоршоо (Шилдэг хоршоо)

❖ **Хүнс, худалдаа, хоол үйлдвэрлэлийн салбарын шилдгээр:**

- “Сэлэнгэ таван хайрхан дундын хоршоо” (Шилдэг хүнс үйлдвэрлэгч)

❖ **Хөнгөн, жижиг дунд үйлдвэрийн салбарын шилдгээр:**

- “Сүүн зам дэйри” ХХК “Номгон моццерелла бяслаг” (Импортыг орлох шилдэг бүтээгдэхүүн)
- Сэлэнгийн бэлчир хоршоо(Шилдэг хоршоо)

Цаг агаарын нөхцөл байдлын улмаас хадлан бэлтгэлийн ажил зарим сумдад харьцангуй оройтож байна. 2021-2022 оны өвөл хавар малчдын түвшинд бэлтгэх хадлан бэлтгэлийн явц 09 сарын байдлаар 57666 тн байгалийн хадлан, 11тн ногоон тэжээл, 18 тн ногооны дарш бэлтгэж хадлан бэлтгэлийн ажил 43,4 хувьтай явж байна.

Байгаль орчны талаар: Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2015 оны 419 тоот тушаалын дагуу нөхөн сэргээлт хүлээж авах ажлын хэсэг Түшиг, Баянгол сумын нутагт орших Баруун Хужиртын хөндий, Баянгол Их Даширын хөндийн “Бороогоулд” ХХК, Нарангийн голын “Тайхаржин майнинг” ХХК-уудын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хэмжиж, хүлээн авч ажиллалаа.

Булаг шандны эхийг хамгаалах ажлыг хийж гүйцэтгэхээр Алтанбулаг суманд гэрээ байгуулсан “Бэлчрийн бүсийн сум дундын Ойн анги”, Хишиг-өндөр ой нөхөрлөлүүдийн булаг шандны эхийг хамгаалсан ажлын гүйцэтгэлтэй танилцлаа

Авилгатай тэмцэх газраас “Хууль бусаар мод бэлтгэх” гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл эрүүгийн хэргийн гаргалтыг бууруулах, ойн санг хамгаалахад төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн төлөөллийг хамруулсан уулзалт, ярилцлага сургалт, сурталчилгаа явуулах, тэдгээрийн санал хүсэлтийг сонсох гомдол мэдээлэл хүлээн авах зэрэг урьдчилан сэргийлэх, арга хэмжээг зохион байгуулах ажлыг зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд сумын 1, сум дундын 5 Ойн анги, ой бүхий сумын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, Мэргэжлийн хяналтын холбогдох хүмүүс зэрэг 32 хүн хамрагдсан.

Мод бэлтгэл, мод модон материал үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг 6 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхээр материал бүрдүүлж ирүүлснээс 4 аж ахуйн нэгжийн материал баримт дутуу буцаагдаж 2 аж ахуй нэгжид үнэлгээ хийж хүргүүлсэн.

Аюултай хог хаягдал үүсгэгч аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг аймгийн хэмжээнд зохион байгуулж нийт 6 төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг 23 иргэн, аж ахуйн нэгжийг бүртгэлжүүлж БОАЖЯ-ны eic.mn мэдээллийн санд бүртгэж оруулаад байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх аян” өрнүүлэх тухай А/265 тоот захирамж, Орхонтуул сумын Засаг даргын гомдол мэдээллийн дагуу Орхонтуул суманд 2 хоногийн хугацаанд хяналт шалгалт хийж, хяналт шалгалтад “Тохой-1”, “Хул азаргын тохой”, “Цагаан давааны нуга”, “Туулын тохой”, “Цагаан гозгор”, “Орхонтуул-4” гэх газруудад ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд, иргэд хамрагдсан ба ямар нэг холбогдох бичиг баримтгүй хууль бусаар ашигт малтмал олборлосон хэрэг зөрчил нийтлэг илэрсэн. Илэрсэн зөрчлийг аймгийн Мэргэжлийн хяналтын газарт шилжүүлэн ажиллалаа.

Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Ерөө сумын “Өлөнтийн алтны шороон орд” “Монлидтрейд” ХХК, Хүдэр сумын “Төмөртэйн төмрийн хүдрийн орд” “Эрдэс групп” ХХК-ууд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2007 оны “Бодлого журам батлах тухай” 39 тоот тогтоолын дагуу ТЭЗҮ, БОНБНҮ-ний тайлан, 2021 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө, 2021 оны ус ашиглах гэрээ, шав тэмдгийн акт зэрэг бичиг баримтын бүрдэлтийг шалгаж хянан баталгааны хуудас олгосон.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар: Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Иргэнд 2021 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай” 262 дугаар тогтоол батлагдаж уг тогтоолоор аймгийн хэмжээнд нийт **682,64** га газрыг **3118** иргэнд өмчлүүлэхээр тогтоосон. Засгийн газрын

тогтоолын дагуу газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг сумдын газрын даамлуудад чиглэл өгч нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж байна.

Иргэнд 2022 онд өмчлүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалтын саналыг Баруунбүрэн, Ерөө, Жавхлант, Сайхан сумдууд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа хэлэлцүүлэн батлуулж, цаг үеийн байдлаас шалтгаалан бусад сумдууд Засаг даргын албан тоотоор саналаа ирүүлээд байна. Аймгийн хэмжээнд 2022 онд шинээр **3038** иргэнд **412,68** га, улсын чанартай автозамын дагуу **500** иргэнд **34,98** га нийт **3538** иргэнд **447.66** га газрыг тус тус өмчлүүлэхээр төлөвлөж Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд төлөвлөгөөний төслийн зургийг нэгж талбар тус бүрээр төлөвлөн оруулаад байна. Уг төлөвлөгөөний төсөлд иргэд олон нийт саналаа цахимаар өгөх боломжтой болсон.

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлын хээрийн судалгааны ажил 17 суманд бүрэн хийж гүйцэтгэн боловсруулалт тайлангийн ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар 7 сум “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлын мэдээг Газрын мэдээллийн сангийн вэб хувилбарт оруулан бичмэл тайланг ирүүлж ажилласан байна.

Хот байгуулалтын мэдээллийн сангийн шинэчилсэн програм хангамж болон архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад хүлээн авах зөвшөөрлийг цахимаар олгох ажилд 2021 онд аймгийн хэмжээнд шинээр барилга угсралтын 9 ажил байгаагаас доорх ажлуудын газар баталгаажуулагдсан байна.

1. Мандал сумын нутагт баригдаж байгаа “Ахмадын өргөө” барилга угсралтын ажил гүйцэтгэгч “Мэргэддэнзэн” ХХК.
2. Ерөө сумын нутагт 200 ортой цэцэрлэг барилга угсралтын ажил гүйцэтгэгч “Таванхан уул” ХХК, “Өвлийн хүлэмжийн” барилга, барилга угсралтын ажил гүйцэтгэгч “Мандал өргөө голомт” ХХК
3. Шаамар суманд “ Гүний худаг” - ийн ажил, барилга угсралтын ажил гүйцэтгэгч “Сүлдханба” ХХК, Дулаанхаан тосгон халуун усны барилга угсралтын ажил гүйцэтгэгч “Хос соёмбот өргөө” ХХК
4. Алтанбулаг сум, Алтанбулаг боомт дах мэргэжлийн хяналтын мал амьтны хорио цээрийн байгууламж , барилга угсралтын ажил гүйцэтгэгч “ Ганзосон констракшн” ХХК.

Эх загвар зураг батлагдсан:

- Ерөө сумын “Өвлийн хүлэмжийн” барилга угсралтын ажил

Барилга эхлэх зөвшөөрөл батлагдсан

- “Ахмадын өргөө” барилга угсралтын ажил .
- Шаамар сум, Дулаанхаан тосгон халуун усны барилга угсралтын ажил.

Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг:

1. Орхон сумын 2-р багийн иргэн Д.Ганбаатарын “Усалгаатай ногооны аж ахуйн гадна цахилгаан хангамжийн ажил”.
2. Баянгол сумын иргэн Б.Энхтайвангийн 10кВ-ын 0.15км урттай цахилгааны агаарын шугам татах,100/10кВА чадалтай КТПН-ны угсралтын ажил. Мандал сумын Ахмадын төвийн барилга. /Мандал сум/
3. “Сүхбаатар сумын зам засвар”-ын ажил.
4. Сүхбаатар сумын 4,7,8-р багт тоглоомын талбай хийх ажил.
5. Сүхбаатар сумын Дулааны шугам татах ажил.

6. Сүхбаатар сумын Дотуур байрны засвар
7. Алтанбулаг сум, 3-р баг, Үхэрчийн аманд Ж.Баяраагийн худалдаа үйлчилгээний цогцолборын гадна цахилгаан хангамжийн ажил.
8. Алтанбулаг сумын зам засварын гэрэлтүүлгийн ажил
9. Алтанбулаг сумын Гэр хорооллыг инженерийн шугам, дэд бүтцэд холбох
10. Сайхан сумын Тавантолгойн хөндий хорих 435-р ангийн хажууд “Хөтлийн занар” ХХК-ий чулуу бутлуур, замаскийн үйлдвэрийн гадна цахилгаан хангамжийн ажил.
11. Сайхан сумын “Мөнх-Орхон” ХХК-ий Усалгаатай талбайн цахилгаан хангамжийн 6/0.4кв-ын дэд станц барих ажил нийт 14 ажилд олгосон байна.

Улсын комисс ажиллаж барилга байгууламжийг ашиглалтад хүлээлцүүлсэн байдал:

1. Орхонтуул сумын Рашаант тосгонд “Бүлээн оргил” ХХК-ий гүйцэтгэсэн “Сумын төвийн жишиг гудамж” байгуулах ажилд улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.
2. Орхон сумын Бэлэндалай багийн 42-р зөрлөгт хийгдсэн бетон замын ажилд улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.
3. “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ий Сүхбаатар сумын төвд гүйцэтгэсэн зам засвар, тэмдэг тэмдэглэгээний ажилд улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.
4. Сүхбаатар сумын 8-р баг “Буурын голын тохижилтын ажилд улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.
5. Сүхбаатар сумын 4-р багт “Гялаан нуур” ХХК-ий захиалгаар баригдсан “Үйлчилгээний төвийн барилга” угсралтын ажилд улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.
6. Алтанбулаг суманд замын сангийн хөрөнгө оруулалтаар “Уран төмөр хэлхээ” ХХК-ий гүйцэтгэсэн зам засвар, тэмдэг тэмдэглэгээний ажилд улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.
7. Зүүнбүрэн суманд замын сангийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Сэлэнгэ есөн эрдэнэ” ХХК-ий гүйцэтгэсэн зам засвар, тэмдэг тэмдэглэгээний ажил
8. Сумын төвийн дотор замын засварын ажлуудад тус тус улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.
9. Алтанбулаг сумын 3-р баг иргэн Ж.Баяраагийн худалдаа үйлчилгээний зориулалттай газрын гадна цахилгаан хангамжийн ажилд улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.
10. Сүхбаатар сумын 4-р багт “Танан цамхаг” ХХК-ий гүйцэтгэсэн “Хуримын ордны хүчитгэл, засвар”-ын ажилд улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.
11. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Даян байгаль” ХХК-ий гүйцэтгэсэн сургуулийн барилгын их засварын ажилд улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

Орон нутгийн өмчийн талаар: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 80, “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх” 81, “Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай” 82 тоот тогтоолуудыг хэлэлцүүлж батлууллаа.

2021 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д 1 агентлаг, 17 сум, 20

сургууль цэцэрлэгийн төлөвлөгөөг хянан баталгаажуулж Сангийн яаманд илгээж батлуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны ХАА-ны төлөвлөгөөнд 89 төсөл арга хэмжээ батлагдсанаас Захиалагчаас 62 төсөл арга хэмжээний ажлын даалгавар, зураг төсөв, техникийн тодорхойлолт ирүүлсэн даруйд ил тод, нээлттэй 100 хувь цахим хэлбэрээр хуулийн хугацаанд зохион байгуулан ажиллаж байна.

Үүнээс тендер шалгаруулалт нь хүлээн авах шатандаа байгаа 13, үнэлгээ хийж байгаа 2, гэрээ байгуулах эрх олгосон 47, Зураг төсөв ирээгүй 25 төсөл арга хэмжээ байна.

Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 153 дугаар тогтоолоор баталсан журам, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 15 дугаар тогтоол, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 50 дугаар тогтоолуудыг үндэслэн Сум хөгжүүлэх сангийн 2021 оны хоёр дахь төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд төслийн хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаатай танилцаж 5 төслийг баталж, санхүүжилтийг олгож эхлээд байна.

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн “Залуучуудын оролцоо” төсөлд 4 иргэн хамрагдаж 2 иргэн ажлын байранд зуучилсан. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийн Аж ахуй эрхлэлтийн сургалтад 15 иргэн хамрууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Цөх 3-р багийн Хяраан голд гүүр шинээр барих ажил эхлээд 20 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн замын сангийн хөрөнгөөр замын гэрэлтүүлгийн засварын ажилд “Хайрхан Уулын зам” ХХК шалгарч сумын төвийн бүх гэрэлтүүлгийг засварлаж, Ерөнхий боловсролын сургуульд 90 метр явган хүний зам шинээр хийж гүйцэтгэж байна

Аймгийн орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр гэр хорооллыг инженерийн шугам, дэд бүтцэд холбох ажилд “Сэлэнгэ-Ундрам” ХХК тендерт шалгарч хөрөнгө оруулалтын ажил, үерийн далангийн засварын ажилд “Эко буянт” ХХК шалгарч засварын ажлууд тус тус эхлүүлээд байна.

Тус сумын ахмадын хороо нь “Улсын тэргүүний ахмадын хороо”-оор шалгарч “Хүндэт өргөмжлөл” гардан авах, сумын “Ахмадын өргөө”-ний нээлтийн үйл ажиллагаа боллоо.

Алтанбулаг Хөдөө аж ахуйн техникумын сургуулийн дурсгалын цогцолбор бүтээн байгуулалтын ажлыг хүлээлгэн өгөх арга хэмжээнд аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга н.Энхбат нар оролцож бүтээн байгуулалтад оролцсон төгсөгч, багш ажилчдыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”, аймаг сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнаж урамшууллаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийг эрчимжүүлэх тухай” А/15 тоот захирамжийн дагуу төр төсвийн 7 байгууллага, худалдаа үйлчилгээний 39 газрын нийт 125,760 м² талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэлээ.

09 дүгээр сарын байдлаар сумын хэмжээнд нийт 264 тохиолдол бүртгэгдсэнээс 229 иргэн эмчлэгдсэн 35 иргэн гэрээр эмчлэгдэж байна. 3 иргэн нас барсан. Тус иргэдийн ойрын болон дам хавьтлыг тодорхойлох тандалт судалгааны ажлыг сумын

Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн “Сумын шуурхай штабыг шинэчлэн байгуулах тухай” А/46 тоот захирамжийн дагуу “Хариу арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажиллагаа- зохицуулах” багийн 6 гишүүн хариуцан ажиллаж байна.

Коронавируст халдвар /Ковид-19/ халдвартай голомтын бүс нутгаас ирсэн, халдварын шинж тэмдэг илэрсэн 131 иргэдэд тандалт судалгааг хийж PCR оношлуурын шинжилгээнд 125, түргэвчилсэн оношлуурын шинжилгээнд 245 иргэдийг хамруулж өдөр бүр сорьцыг зөөвөрлөж эрүүл мэндийн газарт мэдээ өгч ажиллаж байна.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг 3 дугаар тунг 1150 иргэнд, улирлын томуугийн вакцинд 2-11 насны 440 хүүхэд хамрагдсан.

Аймгийн Онцгой байдлын газраас 1.708.0 (Нэг сая долоон зуун найман мянга) төгрөгийн үнэ бүхий 1 удаагийн хамгаалах хэрэгсэл, ариутгалын бодис зэргийг сумын сумын онцгой комисст хандивлалаа.

БШУС, ЭМС-ын хамтарсан 2021 оны А/292, А/525 дугаар “Коронавируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын 2 дахь заалтыг баримтлан 2021-2022 оны хичээлийн жилд 792 сурагч, 67 багш ажиллагсадтайгаар сургалтын үйл ажиллагаа эхэлсэн.

Баруунбүрэн сум:

Тус суманд үр тарианы ургац хураалт 09 дүгээр сарын байдлаар улаанбуудай 200 га талбайгаас 300 тн ургац хураан авч 250 га талбайг ангилаад байна. Төмс хүнсний ногооны ургац хураалтын хувьд 70 га талбайгаас 560 тн төмс, 49,6 га талбайгаас 356,5 тн хүнсний ногоо хураан авсан ба ургац хураалтын мэдээг холбогдох газарт хүргүүлж байна.

Бог малын хээлтүүлэгчийн сууриудаар сумын ХАА-н тасаг, Мал эмнэлгийн тасаг хамтран тойрч хуц, ухнын тарга хүчийг үзэж үзлэг хийж тухайн малчдад нь зөвлөгөө өгч ажиллалаа.

Сумын Засаг даргын 2021 оны “Хяналтын зөвлөл байгуулах тухай” А/127 тоот захирамжийн дагуу сумын хүнсний дэлгүүрүүдэд хяналт шалгалтын ажил зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан ажиллаж байна.

Мал эмнэлгийн тасгаас Парзиттах өвчнийг эмчлэн сэргийлэх арга хэмжээнд ваннд 95 малчин өрхийн хонь 15260, ямаа 13740, шүрших үхэр 150, хонь 6965, ямаа 3280 толгой нийт 39395 толгой мал, амьтдыг хамруулж, 20900 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Мөн 70 гаруй малчин айл өрхөд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, холбогдох заавар, журмыг танилцуулж, малын эрүүл мэндийн өрхийн дэвтрийн бичилт хөтлөлтөд хяналт тавьж, мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч ажилласан.

Сумын Засаг даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/125 тоот захирамжийн дагуу Геодезийн байнгын цэг тэмдэгтийн тооллого явуулах ажлын хэсэг сумын нутаг дэвсгэрт байрлах геодезийн байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллалаа.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах болон сумын 2022 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

2021-2022 оны хичээл сургалтын үйл ажиллагаа эхэлж тус сумын “Д.Мягмарын нэрэмжит” Ерөнхий Боловсролын сургуульд энэ хичээлийн жилд бага ангид 10 бүлгийн 284 суралцагч, дунд, ахлах ангид 10 бүлгийн 243 суралцагч нийт 527 суралцагч, 52

багш, ажилчидтайгаар сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг эхлүүлээд байна. Мөн ЕБС-ийн дотуур байранд хөдөөгийн малчин өрхийн 74 суралцагч хамрагдаад байна.

2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг ханган хичээл сургалтын үйл ажиллагааг танхимаар хичээллүүлсэн боловч тус сургуулийн 15 багш, ажилтан Коронавируст халдвар /Ковид-19/ вирусээр өвчилсний улмаас 09 дүгээр сарын 06-аас эхлэн сумын Онцгой комиссын шийдвэрээр хичээл сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэн, 09 дүгээр сарын 20-оос эхлэн бага ангийн сургалтын үйл ажиллагааг танхимаар эхлүүлээд байна.

Сумын Эрүүл мэндийн төвөөс 09 дүгээр сард Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын Комернети вакцины 2-р тунг 2 иргэнд, 3-р тунг 700 иргэнд хийсэн байна. Мөн Томуугийн вакцинд 2-11 насны 400 хүүхэд хамрагдлаа.

Баянгол сум:

Коронавирусын халдвар /ковид-19/-аас урьдчилан сэргийлж тархалтыг бууруулах зорилгоор сумын Засаг даргын 2021 оны “Түр хязгаарлалт тогтоож, зарим байгууллагын үйл ажиллагааг хориглох тухай” А/108 тоот захирамжийн дагуу 09 дүгээр 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажиллах цагийн хуваарийг 08:00-15:00 цаг хүртэл байхаар тогтоон ажиллаж байна.

Мөн сумын Засаг даргын 2020 оны “Шуурхай штаб байгуулж ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” А\254 дүгээр захирамжийн дагуу Засаг даргын Тамгын газрын байранд шуурхай штабыг байрлуулан 24 цагийн хариуцлагатай жижүүрийг томилж, үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг аймгийн Онцгой комисс болон холбогдох байгууллагад 94244802 дугаарын утсаар болон цахимаар буюу Bayangolshuurhaishtab@gmail.com хаягаар хүргүүлэн ажиллаж байна.

Боловсрол Шинжлэх Ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам батлах тухай” тушаалыг үндэслэн сургууль, цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Сумын хэмжээнд Ковид-19-ын дархлаажуулалтыг ЕБС-ийн 270 хүүхэд нийт 400 иргэнд, түргэвчилсэн шинжилгээг 839 иргэнд, ПСР шинжилгээг 140 иргэнд тус тус хийж, нийтийн эзэмшлийн 37300 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийг зохион байгуулан ажилласан.

Сумын гадаад харилцааг өргөжүүлэх ажлын хүрээнд 09 дүгээр 10-ны өдөр Унгар Улсаас Монгол Улсад суугаа элчин сайд Обрушанский Борбала Аннагийн ажлын айлчлалыг зохион байгууллаа. Айлчлалын үеэр сумын Эрүүл мэндийн төвд 140.0 сая төгрөгийн өртөг бүхий амьсгалын аппаратыг хандивлаж, Унгар улсын ХАА-н үйлдвэрлэл түлхүү хөгжсөн Абашар мужтай Сэлэнгэ аймгийн Баянгол сум хамтын ажиллагааны холбоо тогтоох асуудлыг хэлэлцлээ.

Мөн Унгар Улсын Элчин сайдын яамтай хамтран “Бороо Гоулд” ХХК-ий нөхөн сэргээлтийн талбайгаас олдсон Хүннүгийн үеийн олдворууд дээр тулгуурлан түүх соёлыг сурталчлах хамтын ажиллагааг эхлүүллээ. ХАА-н үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ, иргэдтэй уулзаж хамтран ажиллах чиглэлээр санал солилцсон ба Унгар улсад ХАА-н чиглэлээр докторын болон бакалаврын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах асуудлыг хөндлөө.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөл бөмбөгийн талбай барих, хүүхдийн тоглоомын талбайн тохижилт, зарим хэсгийн зам арчлалт зэрэг ажлуудыг “Бороо гоулд” ХХК, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумын Засаг даргын Тамгын газар, иргэдийн оролцоотой эхлүүллээ.

Аймгийн Онцгой комиссын гишүүн, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга А.Эрдэнэгэрэлээр ахлуулсан ажлын хэсэг 2021 оны хөрөнгө оруулалтын үр дүн, 2021-2022 оны төв суурингийн болон хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил, “Ковид-19” цар тахлын эсрэг хэрэгжүүлж байгаа ажил арга хэмжээтэй танилцлаа.

“Ковид-19 Цар тахлын нөлөөг олон нийтийн оролцоотой бууруулах нь төсөл”-ийн хүрээнд хийгдэх нийгмийн хамгааллын чиглэлийн “Орон нутгийн шууд тусламжийн утас ажиллуулах” ажлын хүрээнд 3 иргэнийг сургалтад хамруулан ажлын байраар хангаж, өрхийн амьжиргааг дээшлүүлэн ажиллалаа.

“Дэлхийн зөн Зүүнхараа” орон нутгийн хөтөлбөрөөс 2019-2021 оны хооронд өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн “Төгсөлтийн аргачлал” төслийг орон нутгийн удирдлагуудад танилцуулах арга хэмжээг зохион байгуулж, өрхүүдийн хийсэн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гаргаж, тус өрхүүдийн амжилт бүтээлийг сурталчлан 20 өрхөд батламж гардуулж цаашид үйл ажиллагаагаа хэрхэн өргөжүүлэх талаар санал бодлоо солилцлоо.

Сумын Засаг даргын А/141 тоот захирамжийн хүрээнд Мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүд төлөвлөгөөт бруцеллэз өвчнөөс сэргийлэх ШТАМ 19 тарилга хийгдлээ.

Мөн “Монгол ВИ ТИ НЕТ” ТББ-аас 2019 оноос эхлэн хэрэгжүүлж буй “Хайрын бэлэг” аяны хүрээнд тус суманд үйл ажиллагаа явуулдаг “Баян наран дария” МЭҮН-тэй хамтран сумын амьжиргааны түвшингөөс доогуур орлоготой 4 өрхөд тус мал эмнэлгийн энэ онд худалдан авалт хийсэн эмийн үнийн дүн 2,4 сая төгрөгтэй дүйцэх үнэ бүхий 16 толгой хонийг үнэгүй олгох үйл ажиллагаа зохион байгуулагдлаа.

Сумын Засаг даргын 2021 оны А/164 тоот захирамжийн дагуу короновирусын халдвар буурахгүй байгаатай холбогдуулан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор эзэнгүй нохой, муур устгах ажил явагдаж байгаа тул багийн иргэдэд гэрийн тэжээвэр нохой, муурыг байнгын уяатай байлгахын анхааруулж утсаар болон багийн фэйсбүүк хуудсаар зар хүргэн ажиллаж байна.

2021 оны ургац хураалтын ажил эхэлсэнтэй холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны “Сумын ургацын штаб байгуулах тухай” А/148 тоот захирамжаар тариаланчид, хадланчдыг мэдээ, мэдээллээр хангах, тайлан мэдээ авах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ургац хураалтын үед Монгол улсад шатахууны хомстол үүсэж байгаатай холбогдуулан сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 5 шатахуун түгээх станцын шатахууны нөөцийг өдөр бүр авч аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах” А/272 тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэнийг хугацаат цэргийн албанд татах ажлыг зохион байгуулж 18-25 насны цэргийн насны иргэдэд зарлан дуудах мэдэгдэл хүргүүлээд байна.

Ерөө сум:

Сумын онцгой комисс цаг үеийн байдалтай холбогдуулан 4 удаа хуралдаж Ковид-19 цар тахал сумын хэмжээнд нэмэгдэж байгаатай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээ, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны талаар хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гарган ажиллаж байна. Мэдээлэл сурталчилгааны ажлын хэсэг “Ерөө сумын Онцгой комисс” Фэйсбүүк хуудсаар дамжуулан Ерөө суманд ковидын нөхцөл байдлын талаарх мэдээлэл, уриалга заавар, зөвлөмж зэрэг 74 удаагийн мэдээлэл, цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг 4 удаа хүргэсэн.

Сумын хэмжээнд гэрийн тусгаарлалтад 09 дүгээр сарын байдлаар 78 өрхийн, 70 том хүн, 49 хүүхэд, өрхөд хамт 36 нийт 155 иргэн байна.

3 дугаар улирлын байдлаар иргэдээс төрийн захиргааны төв байгууллагад нийт 570 өргөдөл, гомдол ирсэн ба түүнээс шийдвэрлэсэн 517, бусад байгууллагад шилжүүлсэн 3, хугацаа болоогүй 50, шийдвэрлэлт 90 хувьтай хэрэгжсэн байна.

1,2,3 дугаар багийн хэмжээнд иргэдээс өрхийн хэрэгцээний хадлангийн 420 өргөдлийг заасан хугацаанд хүлээн авч малчин, мал бүхий иргэдтэй гэрээ байгуулан ажилласан.

2021-2022 оны хичээлийн жилд дунд ангийн 9 бүлэгт 255 сурагч, ахлах ангийн 6 бүлэгт 105 сурагч нийт 15 бүлэгт 360 сурагч суралцаж мэргэжлийн 20 багш сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Соёлын төвийн 60 жилийн ойд зориулан цахимаар 18 удаагийн теле концерт дуу, өгүүллэгийг Ерөө соёл, спорт цахим хаягаар иргэдэд хүргэсэн.

Зорилтот өрхийн иргэдийн ажил байдлын судалгааг гаргаж, 7 иргэнийг ажлын байранд зуучилж ажиллалаа.

“Болд төмөр Ерөө гол” ХХК-ий санхүүжилтээр Ерөө сумын 15 оюутанд 41,750,0 төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлээ.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ-тай хамтран хэрэгжүүлсэн “Төгсөлтийн аргачлал” төсөлд хамрагдсан 30 өрх төгсөлтөө хийж авсан тоног төхөөрөмж, малынхаа ашиг шимээр үзэсгэлэн худалдаа зохион байгууллаа.

Намрын ургац хураалтын ажил 10 хувьтай явагдаж байна. “Намрын ногоон өдөр”-үүд үзэсгэлэн худалдаанд 5 ногоочин оролцлоо.

Шимэгчтэх өвчний хүрээнд: Туулгалтад хонь 29700, ямаа 32000, үхэр 12900, адуу 4500, нохой 1500 гахай 600 нийт 81200 мал амьтанд, боловсруулалтад хонь 23500, ямаа 30000, үхэр 21000, нохой 400, гахай 150 нийт 75050 мал амьтан тус тус хамруулаад байна.

Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын хүрээнд өдөр бүр 570 м² ариутгал халдваргүйтгэл хийж байна.

Жавхлант сум:

Тус суманд 09 дүгээр сарын байдлаар коронавируст халдвар /ковид-19/-ын 141 батлагдсан тохиолдол бүртгэгдэж, тандалтын баг цар тахлын халдварын голомт, тархалтыг хумих, ойрын хавьтлуудыг түргэн шуурхай илрүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.

Сумын Онцгой комиссын гишүүд, Эрүүл мэндийн төвийн болон цагдаагийн албан хаагчид гэрийн тусгаарлалтад орсон иргэдэд халдвар хамгааллын дэглэмээ сахих, зөвлөгөө зөвлөмжийг утсаар өгч байна.

Коронавирусын халдварын нөхцөл байдал, халдварын тархалтаас сэргийлэх, тархалт улам нэмэгдэж байгаатай холбогдуулан урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэг, видео бичлэгийг 15 удаа цахимаар сурталчлан ажилласан.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Бумбат 1-р баг, Моностой 2-р багт, шинээр гудамж зам талбайн гэрэлтүүлгийг ашиглалтад орууллаа.

Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан сумын сургууль цэцэрлэгт 3289 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэлээ.

Коронавирусын эсрэг Файзэр вакцины 2-р тунд 135, 1 тунд 15 хүүхдийг, Синафрам верацелл вакцины 2-р тунд 8 хүн хамруулсан.

09 дүгээр сарын байдлаар улаанбуудай шууд хураалт 300 га талбайгаас 390 тн, улаанбуудай ангилан хадалт 1300 га, тосны ургамал 2100 га ангилж, 42 га талбайгаас

721 тн төмс, хүнсний ногоо хураалт хийж, ургац хураалтад 65 оюутан сурагч, 15 цэрэг ажиллаж байна.

Ургац хураалтын ажил эхэлсэнтэй холбогдуулан сумын малчин болон мал бүхий өрхүүдэд малаа тариалангийн талбайд оруулахгүй, байнга хариулга маллагаатай байх талаар анхааруулга мэдэгдэл өгч ажиллалаа. Үр тариа, төмс, хүнсний ногооны талбайд мал орсон тохиолдолд ургацын хохирол тогтоох комисс газар дээр нь очиж шийдвэрлэн ажиллаж байна.

2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хүрээнд 223 малчин 4133 га талбайд хадлангийн талбайн ашиглалтын гэрээ байгуулан 09 дүгээр сарын байдлаар малдчын түвшинд 2850 тн, сумын аюулгүйн нөөцөд 5 тн хадлан бэлтгээд байна.

Зүүнбүрэн сум:

Засаг даргын Тамгын газрын албан хаагчид Шуурхай штабын даргын баталсан хуваарийн дагуу өдөр бүр гэрийн тусгаарлалт болон ариутгал халдваргүйжүүлэлтийн мэдээг өдөр бүрийн 11:00, 16:00 цагуудад аймгийн Мэргэжлийн хяналтын газарт утсаар болон цахимаар хүргүүлэн ажиллаж байна.

Сумын Онцгой комиссын 2021 оны “Баг байгуулах тухай” 07 тоот тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг 2021 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр /Ковид-19/ халдвараар нас барсан 1 иргэний буяны ажлыг зохион байгуулахад хяналт тавин ажиллаж орчмын 60 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийлээ.

Сумын Засаг даргын 2021 оны “Ургацын штаб байгуулах тухай” А/93 тоот захирамжаар ургацын штабыг байгуулснаар ангилан хураалт 1000 га, шууд хураалт 850 га-гаас 1320 тн хураагаад байна.

Сэлэнгэ мөрөн үерлэсний улмаас 33 өрхийн 6.8 га талбайн 57.6 тн төмс, 60.65 га талбайн 530.05 тн хүнсний ногоо усанд автан ургац алдаж 395.406.0 төгрөгийн бодит хохирол тогтоон аймгийн Онцгой комисст хүргүүлээ.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 215 иргэн 2 аж ахуй нэгжийн 3375 га талбайд хадлан бэлтгүүлэхээр гэрээ байгуулснаар 1100 тн хадлан бэлтгээд байна. Мөн иргэдэд хэрэглээний болон түлшний мод бэлтгүүлэхээр Түшиг сумын Засаг даргад 01/236, Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн ангид 03/141 тоотой хүсэлт хүргүүлэн ажиллалаа.

Улаанбаатар хотод зохион байгуулагдаж буй “Намрын ногоон өдрүүд” арга хэмжээнд сумаа төлөөлөн 4 иргэн оролцож байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас ирүүлсэн “Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 03/387 тоот зөвлөмжийн хүрээнд “Zuunburenzar” цахим сүлжээнд сэрэмжлүүлэг, зөвлөмжийг өдөр бүр байршуулан, голын эрэг орчимд амьдардаг 14 малчин болон ногоочдод утсаар зөвлөгөө өгч ажиллалаа

Байгалийн дагалт нөөц “Дэргэвэр жиргэвэрүү” түүх зөвшөөрөлтэй Дархан-Уул аймгийн “Мөнх-Хакер” ХХК, Улаанбаатар хотын “Гленкорсерус” ХХК, аймгийн харьяат “Хатан- Хайлаас” ХХК-тай тус бүр 5 кг үр түүх гэрээг байгуулан 651.3 төгрөгийг татварын орлого төвлөрүүлж, хяналт тавин ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан ойн хөнөөлт шавьж өвчний тархалт тогтоох судалгааны ажлыг 12 нэгж талбарын 3100 га талбайд хийлгэж хортон устгал хийлгэх саналаа хүргүүлээд байна.

Сумын хэмжээнд 09 дүгээр байдлаар батлагдсан тохиолдлын тоо 120 иргэн байгаагаас эдгэрсэн 82, эмчлэгдэж байгаа 37, нас баралт 1 байна.

“Сумандаа сайхан амьдаръя” төслийн багтай хамтран ажиллаж төр, төсвийн 5 байгууллага, ногоочин болон зөгийн аж ахуй эрхлэгчдийн төлөөллийг орон нутгаа сурталчлах зорилготой телевизийн нэвтрүүлэгт хамрууллаа.

Хичээл сургалтын үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан “Эрсдэлийн үнэлгээний баг” ерөнхий боловсролын сургууль, 1 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж эрсдэлийн үнэлгээ гарган үйл ажиллагааг нь эхлүүллээ.

2021-2022 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль нь 524 суралцагч, 50 багш ажилтантайгаар үйл ажиллагаагаа эхлүүллээ. Сургуулийн дотуур байранд 112 сурагчийг хамрууллаа.

Хүүхдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой “Эцэг эхийн эргүүл” арга хэмжээнд 2 ээлжээр 40 эцэг эх хамрагдлаа.

/Ковид-19/ халдвараас урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын 3-р тунд 323 иргэн, 1-р тунд 13 иргэн хамрууллаа.

Мандал сум:

Сумын Засаг даргын 2021 оны “Олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулахыг түр хязгаарлах тухай” А/200 тоот захирамжийн хүрээнд бүх төрлийн уралдаан тэмцээн, үзэсгэлэн худалдаа зэрэг олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахыг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд түр хязгаарлалаа.

Мөн Сумын хэмжээнд Коронавирус /Ковид-19/ цар тахлын батлагдсан тохиолдлын тоо эрчимтэй нэмэгдэж, халдвар 30-55 насны хөдөлмөр эрхэлж буй иргэдийн дунд, аж ахуй нэгж байгууллагын хүрээнд хурдацтай тархаж байгаад дүгнэлт хийн сумын Онцгой комиссын 2021 оны “Сумын Онцгой комиссын шийдвэр хэрэгжүүлэх тухай” 09 тоот тогтоолыг гарган ариутгал халдваргүйтгэлийн ажлыг чанаржуулж, байгууллагын албан хаагчдад амны хаалтыг тогтмол хэрэглэх, халдвар хамгааллын дэглэмийг сахих, өвчилсөн тохиолдолд авах арга хэмжээний талаар мэдээлэл өгч ажиллахыг аж ахуй нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болголоо.

Сумын Онцгой комиссын шийдвэрээр Нэгдсэн эмнэлгийн сүрьеэ, хүүхдийн, дотрын тасгуудыг Ковидыг эмчлэх тасаг болгон ажиллуулж байна.

2021-2022 оны хичээлийн жил эхэлж байгаатай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны А/190 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг “Сургууль, цэцэрлэгийн бэлтгэл, бэлэн байдал”-д хяналт шалгалт хийж, зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа.

Хичээлийн жилийн бэлтгэл ажлын хүрээнд сумын нэгдсэн эмнэлэгтэй хамтран сургууль, цэцэрлэгийн багш, ажилтныг эрүүл мэндийн үзлэг болон ковидыг илрүүлэх шинжилгээнд бүрэн хамрууллаа. Сумын онцгой комиссын шийдвэрээр өвчлөл ихээхэн гарсан 1 дүгээр цэцэрлэг, Тарни бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын Дарьт дахь салбар бүлэг, ерөнхий боловсролын Түнхэл сургуулийн хичээл сургалтын үйл ажиллагааг цахимд шилжүүллээ.

Суманд үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллагууд дээд шатны байгууллагаас ирүүлсэн чиглэл зөвлөмжийн дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлж, Боловсрол, шинжлэх ухааны сайд, эрүүл мэндийн сайдын 2021 оны А/292, А/525 тоот хамтарсан тушаалаар батлагдсан түр журмын дагуу 5*9 зарчмаар үргэлжлүүлж байна.

Орон нутгийн хэмжээнд корона вирус /Ковид -19/ халдварын тархалт эрс нэмэгдэж, нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан сумын Онцгой комиссоос

эрүүл мэндийн байгууллагуудад нэн шаардлагатай байгаа 5 амьсгал дэмжигч СРАР аппарат, зөөврийн ариутгагч, ариутгалын спиртийг хүлээлгэн өглөө.

Нийт иргэдийг коронавирус /Ковид-19/-ын эсрэг дархлаажуулалт 09 дүгээр сарын байдлаар сенофарм вакцины 2-р тунд 13758 иргэн, 1-р тунд хийлгэсэн 853 иргэн, фэйзер вакцины 1-р тунд хамрагдсан 2137, 2-р тунгаа авсан 246 иргэн, астразенека вакцины 1-р тунд хамрагдсан 71 хүн байна.

Сумын Засаг даргын тамгын газар Сэтгэл зүй хүний хөгжлийн “Шинэ эхлэл төв”-тэй хамтран “Дэлхийн зөн Монгол” ОУБ-ын Сэлэнгэ нэгдсэн хөтөлбөрийн санхүүжилтээр ковидын үед сургууль, цэцэрлэгтээ эргэн орж буй хүүхдүүдийн сэтгэл зүйн нийтлэг асуудал, тэдэнтэй харьцах анхан шатны чадвар олгох агуулга бүхий “Гамшгийн үеийн сэтгэл зүйн бэлэн байдал” сэдэвт сургалтыг зохион байгуулан нийгмийн ажилтан, арга зүйч, сэтгэл зүйч, багш зэрэг 48 хүнийг хамрууллаа.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Олон нийтэд түшиглэсэн урт хугацааны тусламж үйлчилгээний шинэлэг систем, үйлчилгээг хөгжүүлэх” туршилтын төсөлд Мандал сум хамрагдахаар сонгогдож эхний шатны мэдээлэл өгөх сургалт зохион байгуулагдлаа. Сургалтад сумын Засаг дарга, багуудын ахмадын хорооны дарга нар, багийн Засаг дарга, нийгмийн ажилтнууд, Нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлгийн төлөөллүүд оролцсон бөгөөд туршилтын төслөөр идэвхтэй насжилтын төв байгуулах, байнгын асаргаа шаардлагатай ахмад настнуудад өдрийн үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлууд хэрэгжих юм.

Ахмад настны тухай хуулийн дагуу амралтад 11 ахмад, сувилалд 33 ахмад, рашаанд 1 ахмад настныг амрааж нийт 3,9 сая төгрөгийн хөнгөлөлт, протез ортопедийн хэрэгсэл шаардлагатай 22 ахмадад 4,4 сая төгрөгийн хөнгөлөлт олголоо.

Нийгмийн халамжийн тэтгэвэр авдаг нийт хөгжлийн бэрхшээлтэй 300 иргэний судалгааг шинэчлэн гаргав. Үүнээс: 112 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь 70 хувиас доош байгаа бөгөөд 93 иргэн буюу 31 хувь нь хугацаагүй группийн оноштой байна.

Шинэ ажлын байр 104, сул ажлын байр 83, зуучлал 67, ажил хайгч иргэн шинээр 115 иргэнийг бүртгэсэн байна. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөөг 49 иргэнд өгсөн.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулж буй залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” хөтөлбөрт 30 иргэн бүртгүүлснээс 21 иргэн ярилцлагад орж, 13 иргэн вакумжуулсан сургалтад хамрагдсан. Эдгээр иргэдээс 7 иргэн Улаанбаатар хотод дадлага хийхээр гэрээ хийж, 3 иргэн ковид-19 өвчний улмаас эмчилгээнд орж байна.

Ажил олоход хүндрэлтэй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай 13 иргэнийг “Эм эс девелопмент” ХХК-ий дэргэдэх сургалтын төвтэй хамтран хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулав. Сургалт цахим хэлбэрээр зохион байгуулагдаж, батламж олголоо.

Иргэд, бизнес эрхлэгчдэд цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийн хүрээнд “Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл” сэдэвт сургалтыг дээрх сургалтын төвтэй хамтран танхимын хэлбэрээр зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй 15 иргэнийг хамруулсан.

Засаг даргын 2021 оны “Хадлангийн талбай ашиглалтыг сайжруулах тухай” А/168 тоот захирамжийн дагуу 08 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 232 малчин, мал бүхий

өрх, 2 ААНБ-тай гэрээ байгуулсан бөгөөд сумын хэмжээнд 12000 тн байгалийн хадлан, 16 тн дарш, ногооны хаягдал бэлтгээд байна.

Мандал, Түнхэл, Хэрх тосгоны 34 иргэн, аж ахуйн нэгжийн үйлчилгээний газарт МУ-ын "Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 5021-1:2019, "Хоолны газрын үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 4946:2019, "Үс засах үйлчилгээ" MNS 5160:2020, "Хумс заслын үйлчилгээ. Техникийн шаардлага MNS 6843:2020 стандартын дагуу тус тус тохирлын үнэлгээ хийж холбогдох стандартын шаардлага хангасан 27 үйлчилгээний газарт баталгаажуулалт хийж тохирлын гэрчилгээ олголоо.

Малын шилжилт хөдөлгөөнд байнгын хяналт тавих, малын гоц халдварт өвчин дамжих эрсдэлийг багасгах, малын хулгайтай тэмцэх, мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, гарал үүсэл нь тодорхой, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, мал эмнэлгийн арга хэмжээг технологийн хугацаанд гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавих ажлын хүрээнд 75 өрхийн 14 толгой адуу, 54 толгой үхэр, 120 толгой хонь, 15 толгой ямаанд гарал үүслийн гэрчилгээ бичсэн.

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 09 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар нийт 161000 толгой мал, амьтнаас 121882 мал буюу 76 орчим хувийг хамруулаад байна.

Голомтын болон сэжигтэй бүсийн 8 өрхийн малын хашаа, өвчтэй малын бэлчээр болон тоног хэрэгслийг тусгай зориулалтын ариутгалын ДУК автомашинаар 2 хоногт 1 удаа НИСОР нэрийн бодисоор бүрэн халдваргүйтгэж хийж өссөн дүнгээр 271962 м2 талбайд ариутгалаа. 79 үхэрт шүлхий өвчний шинж тэмдэг илрээд байгаа бөгөөд биеийн байдал хүндэрсэн үхэр байхгүй. Одоогоор хонь, ямаа болон гахайд шинж тэмдэг илрээгүй байна.

Австри Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй 400 гэрэлтүүлэг суурилуулах ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. Өнөөдрийн байдлаар 342 гэрэлтүүлэг суурилуулаад байна. Тус гэрэлтүүлгийн трассын дагуу шилэн кабелийн суваг үүсгэх ажлыг эхлүүлж, эхний ээлжид 3 км шилэн кабелийн газар доогуурх сүлжээг байгуулаад байна.

Төмөр замчдын 1 дүгээр багийн 43, 45 дугаар байрны автозам, зогсоол талбайн бетон хучилтыг шинэчлэх ажлыг "Маажин" ХХК хийж гүйцэтгэж байна. Нийт 2300 м2 талбайг тохижилтын ажлыг 10 дугаар сарын 01-ний дотор гүйцэтгэж ашиглалтад оруулахаар төлөвлөөд байна.

Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.15 дах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын төвд 1,1 км бохир усны шугам барих ажлыг "Алтайн үндэс констракшн" ХХК хуваарийн дагуу гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгөхөд бэлэн болоод байна.

Тус сумын Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр хүртэлх Улаанбаатар чиглэлийн 45,2 км, Түнхэл тосгон доторх 4 км хатуу хучилттай автозамын зураг төслийг боловсруулах ажлыг тендерт шалгаран гэрээ байгуулсан "Ар Си Эс Си" ХХК хэрэгжүүлж, ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг санан дурсах тэдний гэгээн дурсгалыг мөнхжүүлэх 26 дах жилийг өдрийг угтан тэдний үр хүүхдүүдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх ажлыг сумын ИТХ-тай хамтран зохион байгуулж, 19 ойн мэргэжлийн байгууллагууд 19 хэлмэгдэгчийн үр хүүхдэд нэг машин түлээний мод үнэгүй олголоо.

Сумын хэмжээнд өвөлжилтийн түлшний бэлтгэлийг хангах үүднээс 11 мэргэжлийн байгууллагад үүрэг өгсний дагуу 9 ойн мэргэжлийн байгууллага одоогийн байдлаар 331,43м³ түлшний модыг доод агуулахад татан төвлөрүүлээд байна.

Орхон сум:

Сумын Засаг даргын 2021 оны А/81 тоот “Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх тухай” захирамжийн хэрэгжилтийг ханган сэрэмжлүүлэг мэдэгдлийг Сайханы ам, Цант чиглэлийн 40 айл өрхөд хүргүүлсэн. Мөн цахим орчинд 5 удаагийн сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг байршуулан ажилласан. Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Орхон голын эрэг дагуу эргүүл, шалгалтыг тогтмол хийн ажиллаж байна. Аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан “Үер, уснаас үрсээ хамгаалъя” сарын аяны хүрээнд анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээллийг “Сэлэнгэ аймгийн Орхон сум”, “Сэлэнгэ Орхон сум ЗДТГ”, “Нарт Орхоны хүүхдүүд” зэрэг фэйсбүүк группт байршуулан иргэдэд хүргэж байна.

/Ковид-19/ цар тахлын тохиолдол нэмэгдэж байгаатай холбоотойгоор хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 7 хүнсний дэлгүүрт тогтмол мэдэгдэл, зөвлөмжийг хүргүүлэн, халдвар хамгааллын дэглэмийг сахиж, халдваргүйжүүлэлтийг 2 цаг тутам тогтмол хийн, маск болон бээлийг тогтмол сольж, үйлчлүүлэгчдийн бүртгэлийг хийж байх зэрэг үүрэг чиглэл өгч ажилласан.

2021 оны намрын хадлан бэлтгэх гэрээг сумынхаа малчин, мал бүхий иргэд, хадлангийн бизнес эрхлэгч 341 иргэнтэй бизнесийн болон малын хадлан тэжээл бэлтгэх 11665 га газарт гэрээ байгуулан ажилласан.

Геодизийн цэг тэмдэгтийн судалгааг газар дээр нь явж үзэн, тайлан мэдээг загварын дагуу мэргэжилтэнд явуулсан. Нийт 27 цэг тэмдэгт бүртгэлтэй байдгаас 12 цэгийг тоолж бүртгэлжүүлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 08 тоот тогтоолын дагуу Баруунбүрэн сумаас 150 иргэн 600 м³ түлшний мод, 100 иргэн 200 м³ гишүү бэлтгэж тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан.

Орхонтуул сумын нутаг дэвсгэрт хууль бусаар ашигт малтмал ашигласан “Сүндэрлэх Орхон” нөхөрлөлийг Зөрчлийн тухай хуулийн дагуу 1.500.0 төгрөгийн торгууль, мөн Орхонтуул сумын иргэн Ж.Гантулгад 100.0 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцсон байна.

Намрын ургац хураалтын ажил эхэлж байгаатай холбогдуулан ХХААГ-т хураалтын мэдээг өгч ажиллаж байна.

М/Д	Төрөл	Ангилсан талбай /га/	Хураасан талбай/га/	Хураасан ургац бүгд /тн/	Га-ийн ургац /цн/
1	Үр тариа				
2	Улаан буудай	2000			
3	Төмс		200	2000	100
4	Хүнсний ногоо		134,3	1637	120
5	Рапс	30			

Хураалтын явцын мэдээг хүснэгтээр харуулав.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “**Намрын ногоон өдрүүд Үндэсний үйлдвэрлэл- 2021**” үзэсгэлэн худалдаанд Бэлэндалай багийн ногоочин Б.Эрдэнэцэцэг хамрагдсан.

Сумын иргэдийн эзэмшлийн үхэр сүргийн үүлдэр угсаа, ашиг шимийг сайжруулах, үхэр сүргийн аж ахуй биологийн эрчимжилтийг нэмэгдүүлэх зорилгоор

аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар “Газар-Агро” ХХК-тай хамтран махны чиглэлийн “Герефорд” үүлдрийн өсвөр хээлтүүлэгчээр хангах арга хэмжээнд хамрагдсан 5 өрхтэй байгуулах гэрээний төслийг боловсруулж сумын Засаг даргаар баталгаажууллаа.

Орхонтуул сум:

Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан сумын Онцгой комиссын хурлын шийдвэрээр нийт хүүхдүүдээ түргэвчилсэн шинжилгээнд хамруулан оруулах ажлыг зохион байгуулж Засаг даргын нөөц хөрөнгөөс 12.8 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж, нийт 580 хүүхэд хамрагдаж 15 хүүхдээс халдвар илэрч гэрийн тусгаарлалтад оруулан ажиллалаа.

Коронавирусын тархалт эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан сумын Онцгой комисс хуралдаж “Тандалт, хариу арга хэмжээний баг”-ийг шинэчлэн томилж ажлын хэсгээр тандалт судалгааны ажлыг эрчимжүүлж гэрийн эмчилгээнд байгаа иргэдтэй өдөр бүр холбогдон зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллаж байна.

18 дээш насны бүх иргэдээ 3-р тунгийн вакцинжуулалтад хамруулах арга хэмжээг сумын Онцгой комисс, Эрүүл мэндийн төвүүд зохион байгуулж нийт 812 иргэн хамрагдлаа. Мөн дархлаажуулалтын томуугийн вакцин хийх ажлыг зохион байгуулж нийт 352 хүүхэд хамрагдаад байна.

Цаг үеийн нөхцөл байдлын талаар Засгийн газар, аймгийн Засаг дарга, Улс аймгийн Онцгой комисс, Эрүүл мэндийн байгууллагуудаас гаргасан заавар, зөвлөмж, шийдвэрүүдийг тухай бүр иргэдэд цахимаар болон шуурхай штабын утсаар мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуулиудын хичээл сургууль эхэлсэнтэй холбоотойгоор Сумын Засаг даргын 2021 оны А/118 тоот захирамжийн хүрээнд Орхонтуул ерөнхий боловсролын сургууль, 1-р цэцэрлэгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллалаа. Дотоод хяналт шалгалтыг Боловсрол соёл шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/292, А/525 тоот тушаалын хэрэгжилтийг хангуулах аймгийн Засаг даргын 2021 оны 02 тоот албан даалгаврын дагуу батлагдсан удирдамжийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

09 дүгээр сард нийт 132 цахим гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж баталгаажуулсан байна. Үүнд амьдаар адуу 45, үхэр 61, хонь 561, ямаа 333 нийт 1000 мал амьтан хүнсний зориулалтаар бичигдсэн байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл худалдаа, хүнсний зориулалтаар: Адуу 1080 кг, үхрийн мах 4160 кг, хонины мах 7660 кг, ямааны мах 2400 кг, гахай 170 кг-д цахим гэрчилгээ бичигдсэн байна.

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад бог төл 50000, бод төл 3900 тарилгыг бүрэн хийж дууссан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Баянцогт 2-р багийн “Хүүхэд залуучуудын талбай”-г засварлах 15.3 сая төгрөг, Баянцогт 2-р багийн “Орон сууц хорооллын тохижилт” 13.5 сая төгрөг, Баянцогт 2-р багт “Лед дэлгэц худалдан авах” 10.0 сая төгрөгөөр хийгдсэн ажлуудыг тус тус хүлээн авч 100 хувь ашиглалтад оруулж ажиллалаа.

Сайхан сум:

Сумын Онцгой комиссын 2021 оны “Хязгаарлалт тогтоох тухай” 03 тоот тогтоолын хүрээнд сумын хэмжээнд Коронавирус (Ковид-19)-ын халдвар цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг авч эрчимжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 09 дүгээр сарын 15-29-ийг дуустал 22:00-05:00 цаг хүртэл шөнийн цагаар хөл

хорио тогтоох, амны хаалтаа авч үйлчлүүлдэг газрууд баар, ресторан, кофе шоп, цайны газар зэрэг хоолны үйлчилгээг 18:00 цагаас хойш танхимаар үйлчлэхийг хориглох, намрын дунд сарын сайн өдөр болон бусад өдрүүдэд хурим, найр хийхийг хориглох, аж ахуй нэгж, албан байгууллага цагийн хязгаарлалт тогтоон ажиллаж байна.

“Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт ба Төрийн албаны шинэтгэл” сэдэвт сургалтад Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчид суусан. Хөдөлмөрийн тухай хуулийн 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжих шинэчилсэн найруулгын онцлох заалтуудыг цахим хаягаар хүргэн ажиллаж байна.

Сайхан сум болон Баруунбүрэн сумын хооронд байгуулсан гэрээний дагуу Баруунбүрэн сумаас мод бэлтгэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Төлөвлөгөөт хяналт шалгалт 1, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн шалгалтаар зөвшөөрөлгүй газар ашигласан 1 иргэнд 500.0 төгрөгийн торгууль тавьж, 45 иргэний түлээний мод 80 м3 гарал үүслийн бичилт хийн ажиллаж байна.

Иргэн О.Цэнгэлмаагийн өргөдөл, гомдлын дагуу Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, Номгон 3-р багийн “Булагтай” гэх маргаан гарсан газарт ажиллаж, О.Цэнгэлмаа болон Х.Мягмарсүрэн нарын маргаан шийдэгдээгүй. Ажлын хэсгийн шийдвэрийг удаа дараа хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд дараагийн шатны дээд байгууллагаар хадлангийн газрын маргаан шийдвэрлүүлэх талаар санал гарган ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын 2021 оны өдрийн 5944 тоотын дагуу зоогийн газар, баар, паб зэрэг нийт 10 ААНБ-уудтай хариуцлагын гэрээ байгуулж цар тахлаас урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын дэглэмийг сахиулахад зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллалаа.

Өрнөх халиугчин ХХК-ий “Өрнөх” хүнсний дэлгүүр, “Отгон” цайны газар, “Баялаг” хэрчсэн гурилын цех зэрэг 3 ААНБ, иргэнд аймгийн Мэргэжлийн хяналтын хамтран эрсдлийн үнэлгээ хийж, зөвлөн туслах үйлчилгээ өгч ажиллаж байна.

Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг 7 хоног бүрийн Баасан гарагт тогтмол зохион байгуулдаг ба нийт 4 удаагийн давтамжтайгаар нийт 67 ААНБ 574.120 м², нийтийн эзэмшлийн 122.737 м², халдвартай бүсийн ариутгал 20.400 м², талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажиллалаа.

Сумын Засаг даргын 2021 оны А/106 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулан хадлангийн газар хуваарлих ажлыг хийж гүйцэтгэсэн. Номгон 3-р баг, Гавшгай 2-р баг, Хөтөл 1-р багийн малчин, мал бүхий иргэдээс хадлангийн газар хүссэн нийт 317 өргөдөл хүлээн авч нийт 3400 га газрыг иргэн бүрд тэгш хуваарлин хадлан бэлтгэх зориулалтаар 1 сарын хугацаатай гэрээ байгуулан ажилласан. Гэрээ байгуулаагүй хадлан бэлгэх асуудал зөрчил гарч байсныг тухай бүр нь зөрчлийг арилган ажиллаж байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Ногоон байгууламж, зам талбайн тохижилт”-ын ажлын гүйцэтгэгч байгууллагатай байнгын холбоотой байж шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн өгч ажлыг эхлүүлэн, Барилга захиалагчийн албанаас өгсөн шаардлагад хяналт тавин ажиллаж байна.

Замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Зам засвар, тэмдэг тэмдэглэгээний ажлын гүйцэтгэлд хяналт тавин, мэдээллийг тухай бүр Барилга захиалагчийн албаны хяналтын инженерт хүргүүлж ажиллаж байна.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хичээллэж байгаа энэ үед өглөө бүр хүүхдийн халууныг хэмжиж, тэмдэглэгээ хийж, амны хаалттай нэвтрүүлж байна. 9 сарын 15 наас эхлэн боловсролын салбарын мэдээллийн системээс багш суралцагч,

ажилчдад QR код хэвлэн өгч 9 сарын 20-ны өдрөөс эхлэн сургууль руу QR кодоор нэвтрүүлж эхэлсэн.

Цаг үеийн нөхцөл байдал, өвчлөлийн тоо нэмэгдэж эхэлсэнтэй холбоотой 09 дүгээр сарын 6-ны өдрөөс эхлэн сургалтын үйл ажиллагааг боловсролын хүрээлэнгээс гаргасан зөвлөмжийн дагуу 5:9 зарчмаар хичээллэж байна.

Цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах түр журамд заасны дагуу заах аргын нэгдлээрээ хэлэлцэн бүлэг зохион байгуулалтаа хийж сургалт үйл ажиллагаагаа эхлүүллээ. Түр журамд заасны дагуу цэцэрлэгт 4-5 настай хүүхдийг бүрэн хамруулж, 2-3 настай хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтыг гэр бүлийн орчинд зайнаас зохион байгуулах чиглэлийн дагуу сургалтын үйл ажиллагаагаа танхим болон зайн хэлбэрээр зохион байгуулж сургуулийн өмнөх боловсролыг тасралтгүй олгож ажиллалаа.

Сант сум:

Сумын хэмжээнд төмс 98 га талбайгаас 980 тн ургац хурааж 58 хувьтай, хүнсний ногоо 97,1 га талбайгаас 974,9 тн ургац хурааж 81 хувьтай ургац хураалтын ажил явагдаж байна. Улаанбуудай 305 га, тосны ургамал 773 га талбайд ангилан хийгдээд байна.

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулж буй “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2021” нэгдсэн арга хэмжээнд сумаас 2 ногоочин хамрагдаж төмс, хүнсний ногооны төрлөөр оролцож байна.

“Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журам”-ын дагуу иргэдийн тариалсан нийт 45 тн төмс, хүнсний ногоонд гарал үүсэл олголоо.

Намрын ургац хураалтын үед шаардагдах шатахууны мэдээг аж ахуйн нэгж бүрээр, сумын ШТС-нд байгаа нөөцийн мэдээг төрөл тус бүрээр гаргаж аймгийн ХХААГ-т мэдээллэсэн. Сумын ШТС нь 7 тн АИ-92, 10 тн АИ-80, 6 тн түлшний нөөцтэй байна.

Сумын малтай 405 өрхийн нийт 254 хуц, 196 ухнад намрын жингийн үзлэг хийж, 128 хуц, 133 ухна шинээр ээмэгжүүлж, бог малын хээлтүүлэгчийг бүртгэлжүүлэлтэд бүрэн хамруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Сумын дүнгээр нийт хуцны 41 толгой буюу 19,2 хувь, ухнын 34 толгой буюу 17,3 хувь нь үржлийн шаардлага хангахгүй байна.

Энэ онд хээлтүүлэгт орвол зохих 18927 эм хонь, 14452 эм ямаа байгаагаас одоо хээлтүүлэгт ашиглагдах 213 хуц, 162 ухна байна. Хээлтүүлэгчийн тохироогоор дутагдалтай 166 хуц, 127 ухна байна.

Иргэдийн хэрэглээ болон түлшний хэрэгцээг хангах зорилгоор 102 иргэнд 443 м3 хэрэглээний мод, 315 иргэнд 2017 м3 галын түлээ бэлтгэх эрхийн зөвшөөрөл олгож улсын төсөвт ойн нөөцөөр 13.551.113 төгрөг, талбай тусгаарлалтад 1.344.500 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжид 1.067.500 төгрөг, нөхөн сэргээлт 3379000 төгрөгийн орлого төвлөрүүллээ.

Иргэдийн мод бэлтгэлийн ажилд хяналт тавих, хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох зорилгоор төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 10 иргэн хамрагдсан байна. Хөдөөгийн малчин болон мал бүхий 40 иргэдэд хог хаягдал болон үер усны аюулаас сэргийлэх талаар зөвлөмж тараасан.

Сумын Онцгой комиссын бүрэлдэхүүн хуралдаж коронавируст халдварын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хичээл сургалтын үйл ажиллагаа зэрэг цаг үеийн асуудлуудыг хэлэлцэж мэдээлэл солилцлоо. Онцгой комиссын хуралдааны шийдвэрээр ойрын хавьтал болсон иргэдийг түр журмын дагуу 14 хоног гэрийн тусгаарлалтад байлгаж шинж тэмдэг илэрсэн тохиолдолд түргэвчилсэн оношлуураар

шинжилгээ авах, түргэвчилсэн оношлуурын нөөц бүрдүүлэх, хурим, шинэ гэрийн найр, хүүхдийн сэвлэг үргээх гэх мэт олныг хамарсан арга хэмжээг хориглох, хандивын мал үнэлэх үнэлгээний баг байгуулах зэрэг асуудлуудыг нэн даруй шийдвэрлэж ажиллахыг холбогдох албан тушаалтан, удирдлагуудад үүрэг болголоо.

Сумын Онцгой комиссоос хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын байгууллага орчмын бүсэд эрсдэлийн үнэлгээ хийх, “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын бэлэн байдалд тавих хяналт шалгалтыг зохион байгууллаа. Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын А/292, А/295 тоот хамтарсан тушаал Коронавируст халдварын үед Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулах дотоодод мөрдөх түр журмыг гаргаж багш, ажилчдад танилцуулж, тус бүртэй гэрээ байгуулсан байна.

Сумын хэмжээнд ковидоор өвчилсөн ЕБС, цэцэрлэгт хамрагддаг 4 хүүхэд бүртгэгдэж ойрын болон дам хавьтлын судалгаа тандалтыг хийсэн. Одоогоор хичээл сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ, Мобиком корпорацтай хамтран зохион байгуулсан “Smart education” арга хэмжээнд сумаас 15 хүүхэд, нөхөн үржихүй бэлгийн боловсрол олгох үе тэнгийн сургагч багш бэлтгэх сургалтад ЕБС-ийн охидын бүлгэмийн 9 сурагч 1 багш, мөн сайн дурын ажилтан бэлтгэх цахим сургалтад сумаас 7 иргэн тус тус хамрагдлаа.

“МОНГОЛ ВИ.И.ТИ.НЕТ” ТББ нь суманд нэг өдөр ажиллаж малчин болон мал бүхий иргэдэд шинээр гарсан малын эм бэлдмэлийн талаар сургалт мэдээлэл хийж, “Хайрын бэлэг” төсөл арга хэмжээний хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай сумын 4 өрхөд дэмжлэг үзүүлж өрх тус бүрт 4 хонь хандивлалаа.

Сумын Ерөнхий боловсролын сургууль нь энэ хичээлийн жилд 12 бүлэгт 315 суралцагчидтайгаар хичээл сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлэн ажиллаж байна. 1-р ангид 35 хүүхэд элсэн суралцаж 6 настны хамран сургалт 69.2 хувьтай. “Үдийн хоол хөтөлбөр”-т 1-5 дугаар ангийн 150 суралцагч хамрагдаж байна. Дотуур байранд нийт 51 суралцагч амьдарч байна.

2021-2022 оны хичээлийн жилд цэцэрлэгт тойргийн нийт 187 хүүхдээс бага бүлэгт 20, дунд бүлэгт 30, ахлах бүлэгт 25, бэлтгэл бүлэгт 26 нийт 101 хүүхэд хамрагдах төлөвлөгөөтэйгээс бага, дунд бүлгийн 50 хүүхэд, ахлах, бэлтгэл бүлгийн 10 хүүхэд цахим хичээлд хамрагдаж байна. Танхимаар нийт 41 хүүхэд хичээллэхээс одоогийн байдлаар 17 хүүхдийн ирцтэй байна. Өвчтэй 3, чөлөөтэй 8, тасалсан 13 байна.

Сүхбаатар сум:

2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажил хангах сумын Засаг даргын захирамж гарч харьяа төр төсвийн байгууллагуудад тараан Засаг даргын орлогчоор батлуулсан удирдамжийн дагуу ажлын хэсэг ЕБС, цэцэрлэгүүдээр өвөлжилтийн бэлтгэл ажлын хяналт шалгалт хийж заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

2021 оны хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлага зохион байгуулах сумын Засаг даргын захирамж гарч багуудад тараан бэлтгэл ажил ханган ажиллаж байна.

“Сүхбаатар сум Сэлэнгэ аймаг”, “Сүхбаатар сум ЗДТГ” гэсэн цахим хаягуудаар Коронавируст \ковид-19\ халдварт өвчний цаг үеийн нөхцөл байдлын сэрэмжлүүлэг

мэдээ, зөвлөмж, мэдээ, мэдээлэл, видео контент тус тус байршуулан иргэдэд мэдээлэн ажиллаж байна.

Аймгийн Онцгой байдлын газрын даргын 2021 оны өдрийн 31/281, 31/286 тоот албан бичгүүдийн дагуу иргэдэд үер усны ослын аюулаас урьдчилан сэргийлэх, гол, мөрөн, нуур тогтоол усанд иргэд болон болон бага насны хүүхдийг осолдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр шторк, зурагт сурталчилгааг хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Коронавируст /Ковид-19/ өвчнөөс урьдчилан сэргийлэх 3 дахь тунгийн вакцинд нийт 3321 иргэн хамрагдаж, 2-11 нас хүртэлх хүүхдүүдэд улирлын томуугын эсрэг вакциныг өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хийгдэж байна.

09 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газарт “ТАНДАЛТ СУДАЛГААНЫ БАГ” ажиллаж нийт 480 иргэдээс тандалт судалгаа авч Өрхийн эрүүл мэндийн төвтэй холбон зуучлах, эмийн багц тараах, халдвар авсан иргэний ойрын хавьтал болсон иргэдийг ПСР шинжилгээнд хамруулах ажлыг хийж байна.

09 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн сумын “Номт хан”, “Эмнэх” ӨЭМТ-үүд АОК-ын 2021 оны 28 тоот тогтоолын дагуу Дулаанхаан тосгоны эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан Эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх гэрийн эргэлтийн 160,0 төгрөгийн багцын үйлчилгээг харьяа өрхийн иргэдэд хүргэж байна. “Номт хан”, “Эмнэх” ӨЭМТ-үүд магадлан итгэмжлэлд орж дүгнэлтээ ЭМЯ-нд хүргүүлсэн.

2021-2022 оны хичээлийн жилд Сүхбаатар сумын ЕБС-ийн 1-р ангид 545 хүүхэд шинээр элсэн орж байна. СӨБ-д нийт хамрагдвал зохих хүүхдийн 2-3 насны хүүхдүүд цахимаар 50 хувь буюу 4-5 насны хүүхдүүд танхимаар хамрагдаж 5 настан бүрэн хамрагдлаа. Яаралтай тулгамдаж байгаа зарим асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Спортын сургууль, 1-р сургуулийн дотуур байрны засварын ажлыг аймгийн хөрөнгө оруулалтаар шийдлээ.

Сумын хэмжээнд СӨБ-д хамрагдах 5 настны болон 1-р ангид шинээр элсэх хүүхдүүдийн судалгааг гарган хүн амын тоотой тулгалт хийж завсардалт үүсгэхгүй ажиллаж байна.

АНУ-ын санхүүгийн дэмжлэгээр баригдсан 5-р багийн 7-р цэцэрлэгийн өргөтгөлийн 2 бүлгийг улсын комисс хүлээн авч хичээл сургалт эхэлсэн. 3-р багийн 8-р цэцэрлэгийн байр ашиглалтад орж 150 хүүхэдтэй үйл ажиллагаагаа эхлээд байна. /Ковид-19/-ийн халдвар илэрсэн анги, багш нарыг журмын дагуу тусгаарлан цахимд шилжүүлэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын Б/21 захирамжаар 2021 оны сумын ургац хураалтын штабыг байгуулж, холбогдох ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Сумын хэмжээнд ургац хураалт төмс 61 га талбайгаас 579,5 тн, хүнсний ногоо 48,2 га талбайгаас 470,5 тн тус тус хураан авч ургац хураалт 75 хувьтай явагдаж байна.

Ургацын хохирол тогтоох ажлын хэсгийг сумын Засаг даргын Б/25 захирамжаар байгуулан Боргүвээ 5-р багт байрлах ногооны талбайд мал орж талхалсан тухай иргэний ирүүлсэн өргөдлийн дагуу ургацын хохиролыг тогтоон акт гарган ажиллалаа.

Аймгийн Засаг даргын “Мал өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлыг хангах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай” А/146 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2021 оны “Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” А/181 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 18 тоот тогтоолыг үндэслэн Сүхбаатар сумын хэрэгцээнд хуваарилагдсан үйлдвэрлэлийн огтлолоор бэлтгэх хэрэглээний нарс 500 м3, хус 1000 м3, ойн цэвэрлэгээний ажлаар бэлтгэх нарс 500м3, хус 100 м3 модыг Хүдэр суманд үйл ажиллагаа явуулдаг ойн мэргэжлийн байгууллагаар 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 12 дугаар сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд бэлтгүүлж, нийлүүлэхээр гэрээ байгууллаа.

Иргэдийн амьдрах ая тухтай орчинг бүрдүүлэх, сумын өнгө үзэмжийг сайжруулах, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй халдварт өвчнөөс сэргийлэх зорилгоор сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төр төсвийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын албан хаагчид, иргэд орчныхоо хогийг цэвэрлэж, нийт 12 тн хогийг төвлөрсөн хогийн цэгт хаяж зайлууллаа.

Сүхбаатар сумын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын болон Ковид-19 цар тахлын халдвар гарсантай холбогдуулан хэвтэн эмчлүүлж буй иргэдийн “Аюултай хог хаягдал”-ыг ачиж, тээвэрлэн төв хогийн цэгт хүргэн, шатааж устгасан.

Зам талбайн 9 үйлчлэгчид өөрсдийн хуваарьт 15000-16000 м2 нийтийн эзэмшлийн зам талбайг өдөр бүр цэвэрлэн ажиллаж байна.

Австри Улсын Засгийн газрын хөрөнгөөр “Дэд бүтэц төслийн хүрээнд” 800 ширхэг гэрэлтүүлэг хийгдэж байгаатай холбогдуулан Хонгор морьтын 1-р баг, Бор гүвээний 5-р баг, Буур хээрийн 8-р багуудад хийгдэж байгаа гэрэлтүүлгийн ажилд зайлшгүй зам сэтлэх шаардлагатай ажлуудад хяналтыг тавьж замыг сэтлүүлэн “Сэлэнгэ-АЗЗА” ТӨХК-аар хийж гүйцэтгүүлж байна.

Ойрын өдрүүдэд хур бороо их орж байгаатай холбогдуулан үерийн далантай Цагаан эргийн 2-р баг, Салхит 3-р баг, Баянхан 4-р багуудад байрлах үерийн далангуудыг сэргээх хог шороог цэвэрлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа. Мөн замын сангийн хөрөнгөөр хот доторх нийт 510 м2 зам талбайн нөхөөс, 30 гаруй туслах замын уулзваруудын сэтэлгээг нөхөн сэргээх ажиллагааг “Сэлэнгэ-АЗЗА” ТӨХК хийж гүйцэтгэн улсын комисс ажиллуулан байнгын ашиглалтад оруулаад байна. Мөн аймгийн хөрөнгө оруулалтаар Ган замын 7-р баг 5-58 айлын урд 20.0 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын талбайн ажлыг байнгын ашиглалтад оруулах ажлыг хүлээн авах ажлын комисс ажиллалаа.

Түшиг сум:

Хичээлийн шинэ жилийн үйл ажиллагааг халдвар хамгааллын дэглэмийг сахиулан, ариутгал халдваргүйтгэлийг эрүүл мэндийн төв болон сургууль, цэцэрлэг өөрсдийн боломжоо ашиглан хийж гүйцэтгэж байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 3 бүлэгт 4-5 настай 65 хүүхэд танхимаар, цахимаар 2-3 настай 78 хүүхэд хичээллэж байна. Ерөнхий боловсролын сургуульд 15 бүлгийн 357 сурагч 12 танхимд суралцаж, дотуур байранд 59 сурагч хүлээн аваад байна.

Коронавирусын халдвар бүртгэгдсэнтэй холбоотой 2 бүлэг цахимд шилжиж 7-14 хоног хичээллэж байгаад буцаад танхимаар хичээллэснээр өнөөдрийн байдлаар 100 хувь танхимаар хичээллэж байна.

Сумын Засаг даргын 2021 оны 78 тоот захирамжаар ургац тогтоолт явуулах ажлын хэсгийн нийт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж,

Ургац тогтоолтоор: Үр тариа 9415 га-с 15537 тн, Төмс 17 га-с 170 тн, Хүнсний ногоо 20,7 га-с 200 тн гаруй ургац хураахаар байна. сумын хэмжээнд ургац 16,5 цн-тэй байна. Төмс 17 га-д тариалалт хийснээс 10 га талбайгаас 100 тн төмс хураан авч, хүнсний ногоо 20,7 га-д тариалалт хийснээс 15,5 га талбайгаас 112,1 тн ургац хураан авч хураалтын ажил явагдаж байна. Одоогийн байдлаар нийт 12639 га-д тариалалт хийснээс: үр тариа 9415 га талбайгаас 370 га талбайгаас 712 тн улаанбуудай хураан аваад байна. Ургац хураалт болц бага зэрэг чийгтэй байгаа тул ургац хураалт удаашралттай байна.

53 малчин өрхөөр 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллан, өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбогдуулан өвс, тэжээл, түлээ нүүрсээ бэлтгэх талаар мэдэгдэж, үйл ажиллагааны орлогын татвар, хадлангийн төлбөрийг цаг хугацаандаа төлөхийг, малаа хариулгатай байлгах талаар мэдэгдэл хүргүүлсэн.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх 2-р тунгийн дархлаажуулалтад хамрагдаагүй 5 хүүхдийг, 3-р тунгийн дархлаажуулалтад 295 хүн хамруулж урвал хүндрэл гаргаагүй ажиллалаа.

Сумын хэмжээнд нийт халдварын тохиолдол 235 бүртгэгдсэнээс 22 иргэн гэрээр эмчлэгдэж байна, 213 иргэн эдгэрч гарсан. 9 дүгээр сард 2 иргэнийг Цагааннуур сумын ковидын тасагт хэвтэн эмчилсэн.

Алтны шороон ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа “Шар нарст” ХХК техникийн нөхөн сэргээлт 2 га-д, биологийн нөхөн сэргээлт 2,2 га-д хийж, “Шинэ бадрах” ХХК “Хар горхи”-д хийсэн 50 га ойжуулалтын нөхөн тарилтыг 100 хувь хийж гүйцэтгэсэн.

Коронавирусын /COVID-19/ цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Засаг даргын нөөцөөс 1.489.100 төгрөг гарсан.

Хушаат сум:

Сумын Онцгой комисс 3 удаа хуралдаж “Хязгаарлах арга хэмжээний тухай” 2021 оны А/82 тоот захирамжаар хүнсний дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарьт өөрчлөлт оруулж орой 20 цаг хүртэл ажиллуулах, дэлгүүрүүдийг тогтмол ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэн өдөр бүр мэдээ авч байх, 12 хүртэл насны хүүхдүүдэд хүнсний дэлгүүрээр үйлчлэхгүй байх, хурим, сэвлэг үргээх найр зэргийг зохион байгуулахыг хориглох зэрэг хязгаарлалтуудыг тогтоон мөрдөж ажиллаж байна.

Сумын Засаг даргын “Цаг үеийн ажлыг эрчимжүүлэх тухай” 2021 оны А/83 тоот захирамжаар “Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө”, “Ургац хураалт, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажил, арга хэмжээний төлөвлөгөө” “Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө” зэргийг хавсралтаар батлан байгууллага, албан тушаалтнуудыг үүрэгжүүлэн ажиллаж байна. “Тандалт, хариу арга хэмжээний багийг шинэчлэн байгуулах тухай” 2021 оны А/78 тоот захирамж гарган тандалтын болон гэрийн тусгаарлалтын дэглэмийг тогтмол хянаж байна. Энэ сард нийт 140 иргэн ковидийн шинжилгээ өгснөөс түргэвчилсэн шинжилгээ 120, PSR шинжилгээг 20 иргэнээс авч 57 иргэний ковидын халдвар батлагдан 6 иргэнийг аймаг, бусад сумдын эрүүл мэндийн байгууллагад эмчлүүлэхээр шилжүүлж 51 иргэн сумын Эрүүл мэндийн төвийн хяналтад гэрээр эмчилгээ хийгдсэн. 9 дүгээр сарын байдлаар өвчилсөн 16, ойрын хавьталын 14 иргэн гэрийн тусгаарлалтад байна.

Аймгийн замын сангийн 32,5 сая төгрөгийн хөрөнгөөр “Сэлэнгэ есөн эрдэнэ” ХХК Орхон голын гүүрнээс 96-р зөрлөг хүртэл 3 га зам засварын ажлыг гүйцэтгэлээ.

Ургацын зам засварын ажлын хүрээнд Мэргэн, Хашаатын даваа орчмын 8 км замыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Сэлэнгэ АЗЗА” ХХК хийж гүйцэтгэлээ.

Мөнхтолгой, Даагат багийн хүүхдийн тоглоомын талбайг сэргээн засварлах ажлыг сумын Орон нутгийн хөрөнгийн сангийн 18.0 сая төгрөгөөр 100 хувь гүйцэтгэн хүлээн авлаа.

Ургац хураалтын мэдээ: Ангилан 1210 га, цайруулалт 400 га-гаас 930 тн, шууд 1095 га-с 1054 тн, рапс 1500 га-с 1270 тн, төмс 58 га-с 660 тн-ийг хураан аваад байна. Ургацын хохирол тооцох ажлын хэсэг нийт 5 удаа мэдээллийн дагуу ажиллан 12 нэгж талбарт 6.7 сая төгрөгийн хохирлыг барагдуулан ажиллалаа. Орхон гол дагуу хүнсний ногоо тариалдаг 20 ногоочны 47 га талбай үерт автан 430.0 сая төгрөгийн бодит хохирол учирч сумын Засаг даргын 2021 оны “Ургацын хохирол тооцох тухай” А/70 тоот захирамжийн дагуу ургацын хохирол тооцох ажлын хэсэг ажиллан нийт 430.0 сая төгрөгийн бодит хохирлыг тооцож зохих байгууллагуудад мэдээлж ажиллалаа.

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг сумын Засаг даргын захирамжийн дагуу тугал 3180 толгой, хурга 13185 толгой, ишиг 9315 толгойг технологит хугацаанд хяналт тавьж хамруулсан байна.

Байгаль орчны чиглэлээр Ойн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж нөхцөл байдлыг зөрчсөн 2 иргэний зөрчлийг илрүүлэн 177 ширхэг модыг хураан авлаа. 250 иргэнд мод бэлтгэх эрхийн бичиг олгон 5125.340 төгрөгийн орлого орууллаа.

Хүдэр сум:

Засаг даргын зөвлөл 2 удаа хуралдаж цаг үеийн холбогдолтой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Аймгийн 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй төмс хүнсний ногооны стандартын зорь барих ажлыг “Сэлэнгэ Есөн хэлхээ” ХХК гүйцэтгэж, 80 хувьтай явагдаж байна. Мөн Орон нутгийн хөрөнгийн сангийн 9.500.0 төгрөгийн санхүүжилтээр хийгдсэн “8-ын гүүрний засвар арчилгаа”-ны ажлыг “Хүдэр Төхижилт” ОНӨААТҮГ 100 гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.

Сумын төсвийн 476,076,100 төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Сумын төвд зам тавих тэмдэг тэмдэглэгээ хийх” 922м бетонон зам тавих ажлыг “Ноблероуд” ХХК эхлүүлээд байна.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ-тай хамтран ЕБС-ийн дотуур байрны хүүхдүүдэд 245.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай “Ариун цэврийн байгууламж” барих ажил эхлээд 60 хувийн гүйцэтгэлтэй явж байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд иргэд, ААН-ийн бизнесийн хадлан бэлтгэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Одоогийн байдлаар хадлан бэлтгэх ажил 75 хувьтай буюу малчид 3000 тн, ААН 100 тн хадлан бэлтгээд байна. Сумын нөөцийн өвс бэлтгэх зорилгоор бизнесийн хадлан бэлтгэх ААН-ээс 150, иргэнээс 50 боодол өвс авахаар гэрээ байгуулан ажиллаж байна.

Нийт төмс хүнсний ногоог хурааж байгаа боловч, үр тарианд /улаанбуудай/ хураах ажилд болц оройтсон бороо ихтэй байгаа тул хураалтад 2 ААН орж, улаанбуудай 235 га-гаас 261 тн, төмс 30 га-гаас 280 тн, хүнсний ногоо 12 га-гаас 107 тн тус тус хураан аваад байна.

Сум хөгжүүлэх сан төлөвлөгөө ёсоор 71 сая төгрөг 100131355401 дансанд байршуулахаас 61 сая төгрөг оруулаад байна. Төслийн зээлд 17 иргэн хамруулж 11 иргэний зээл олгогдсон.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2021 оны 01/10 дугаартай удирдамж, 2021 оны 02/1793 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай”, аймгийн МХГ-ын даргын 2021 оны өдрийн 18/02 тоот “Хяналт шалгалт хийх тухай” байнгын удирдамж, сумын Засаг даргын “Хяналт

шалгалт хийх тухай” захирамжийн дагуу сумын Тарвагатай 1-р багийн Шоргоолж гэх газарт ашигт малтмал олборлох эрхтэй “Дунар-од” ХХК-ий үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, шалгалтын явцад илэрсэн зөрчлийн дагуу арга хэмжээ авч орон нутгийн төсөвт 10.0 сая төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

Сумын Засаг даргын “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай” захирамжийн хүрээнд хяналт шалгалтыг 3 удаа хийж, мод бэлтгэх эрхийн бичигт заагдсан хэмжээ хэтрүүлэн тээвэрлэлт хийсэн 2 иргэний зөрчлийг арилгуулан ЗӨВЛӨМЖ хүргүүлэн ажилласан. Ойн тухай хууль тогтоомж зөрчсөн 1 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч ажилласан.

“Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хүрээнд төмрийн хүдэр олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Дархан төмөрлөг” ХХК нь “Хүдэр эв энерги” ХХК-тай хамтран Баянцагаан 2-р багийн нутаг дэвсгэр Цагаан зүрийн гол дагуу техникийн нөхөн сэргээлтийг 15 га, биологийн нөхөн сэргээлтийн ажлыг 5 га талбайд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж, гэрээний дагуу техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 5 га талбайд хийж гүйцэтгээд байна.

2020-2021 онд захиргааны журмаар хураагдсан 204 шоо метр модыг сумын Засаг даргын захирамжийн дагуу “Дуудлага худалдаа” зохион байгуулан актаар хүлээлгэн өглөө.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор орон нутгийн болон Сүхбаатар, Шаамар сум, Дулаанхаан тосгоны түлээний мод бэлтгэлийн ажлыг зохион байгуулан одоогийн байдлаар мод бэлтгэлийн гүйцэтгэл нарс 4017 м3, түлээ 70 м3 бэлтгэгдсэн байна.

Монгол Улсын Засгийн газраас зарласан “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд 14 хоногийн сургалтад 2 иргэнийг хамруулан, ажилд зуучлаад байна.

“Дэлхийн Зөн Монгол” Сэлэнгэ нэгдсэн хөтөлбөрөөс 8-11 ангийн төлөөлөл болох 11 хүүхэд, сургуулийн нийгмийн ажилтан, эмч нарт “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” сэдвээр зохион байгууллаа. Мөн тус байгууллагаас сумын Хүүхдийн сайн сайхны төлөө зөвлөлтэй хамтран ерөнхий боловсролын сургуульд 2-3 хүүхэд нь хамрагддаг өрхийн амьжиргааны түвшин доогуур орлоготой өрх бүрийн 1 хүүхдэд иж бүрэн хичээлийн хэрэгсэл олгосон ба тус тусламжид сумын 100 сурагч хамрагдсан.

Ковид-19 өвчнөөс сэргийлэх пфайзер вакцин 3 тунг нийт 600 хүнд хийгдсэн. Астразеника вакцины 1,2-р тунд 3 хүн, Вероцелл вакцинд 45 хүн хамрагдсан хийгдсэн. Пфайзер вакцинд хамрагдвал зохих сумын иргэдийг 100 хувь хамруулсан. Дархлаажуулалтын дараах хариу урвал, хүндрэлийн талаар вакцин хийлгэсэн хүүхдийн эцэг эх асран хамгаалагчдад зөвлөгөө өгч ажиллав.

Ковид-19 халдвараар батлагдсан 84 тохиолдол байна. Үүнээс 71 иргэнд дэмжих багцыг гэрээр очиж өгөн эмчилж байна. Батлагдсан хүнд, хүндэвтэр жирэмсэн эх, хүүхэд нийт 7 иргэнийг Сэлэнгэ Нэгдсэн эмнэлэгт цаг алдалгүй хүргэн үйлчилж байна.

Ерөнхий боловсролын сургууль бага ангид 320, дунд ахлах ангид 307 нийт 627 суралцагчтай, 57 ажилтан албан хаагчтайгаар танхимын сургалтын үйл ажиллагаагаа эхэллээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 01\811 тоотын дагуу Эрүүл мэндийн сайдын 2017 оны А145 дугаар тушаалын дагуу байгууллагын багш ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журмыг хэрэгжүүлэн 100 хувь хамрагдсан. Танхимаар хамруулах 4-5 насны 4 бүлгийн 116

хүүхдэд цагаан хорхой, шээсний шинжилгээнд хамруулж, танхимаар 59 хүүхэд зайнаас 57 хүүхэд суралцаж байна.

Танхимаар хүүхэд өдрийн ор хоног 14 хоногт 962 хүүхэд өдөр байхаас 365 хүүхэд өдөр явж 37 хувьтай хамрагдаж байна. 2-3 насны 123 хүүхдэд бүлгийн багш нар зайн сургалтыг өгч ажиллаж байна.

Цагааннуур сум:

Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын Онцгой комисс, шуурхай штабын бие бүрэлдэхүүн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ажиллаж Засгийн газар, улс, аймгийн Онцгой комиссоос гаргасан албан даалгавар, тогтоол, шийдвэр, чиглэлийн дагуу ажиллаж байна.

Суманд 165 иргэн коронавируст халдварт өвчнөөр өвчилж, эдгэрсэн 124 иргэн байна. Үүнээс 0-17 насны 21, 18-аас дээш насны 144 иргэн байна.

Эрүүл мэндийн төвийн ковидын тасагт 09 дүгээр сарын байдлаар 28 батлагдсан тохиолдол, 1 ойрын хавьтал хэвтэн эмчлүүлж байна. Үүнээс 0-17 насны 2, 18-аас дээш насны 26 иргэн байна.

Тус сард томуугийн вакцинд 2-11 насны 520 хүүхэд, ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 900 иргэн хамрагдсан.

Сумын хэмжээнд хонин толгойд шилжүүлснээр 305.0 мянган толгой мал өвөлжихөөр урьдчилсан тооцоо гарч, өвөлжих малын 30 хувийг нэмэгдэл тэжээлд оруулахаар тооцож урьдчилсан байдлаар 16.0 тн хадлан бэлтгэх судалгааг малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж бүрээр гаргасан. 09 дүгээр сарын байдлаар 245 иргэн 4650 га-д, 7 аж ахуйн нэгж 1450 га-д 9600 тн хадлан бэлтгээд байна.

Улаанбуудай ангилан 3492 га, шууд хураалт 2889 га, хураасан 4498 га-с нийт ургац 6398 тн дундаж га-с 14,2 цн, рапс ангилан 2554 га, шууд хураалт 1140 га, хураасан 2080 га-с нийт ургац 1280 тн, дундаж ургац 6,2 цн байна.

Томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 1600 толгой адуу, галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 800 нохой, гайхан цусан халдварт иж балнад өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 748 толгой гахай хамруулж тус тус 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд боловсруулалтад бод 19344, бог 70908, гахай 446, нохой 95, туулгалтад бод 13449, бог 65538, нохой 659, гахай 285, угаалгад бод 15556, бог 101732, гахай 323 толгой тус тус хамруулсан.

Халдваргүй өвчний 10 удаагийн дуудлага ирж, мал эмнэлгийн цахим гэрчилгээ 152 бичигдсэн.

“Гүн шүрэн”, “Баянбүрд” нөхөрлөл, мод бэлтгэлийн мэргэжлийн байгууллага болох “Бүтээлийн нуур” ХХК, “Шинэ бадрах” ХХК-ий мод бэлтгэсэн талбайг хамтарсан ажлын хэсэг хүлээн авсан.

Шаамар сум:

Монгол Улсын Засгийн газрын 105 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны “Түр журам батлах тухай” 46 дугаар тушаал, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны А/292, А/525 тоот хамтарсан тушаалыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн эрчимжүүлэх” А/15 тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Шаамар сум Дулаанхаан тосгоны төр, төсвийн нийт 32, худалдаа үйлчилгээний 18 байгууллагын 21586,2 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажилласан.

09 дүгээр сард Коронавирусын нийт 39 тохиолдол бүртгэгдсэн. Батлагдсан тохиолдлыг насны ангиллаар тархалтыг авч үзвэл 0-17 насны 8, 18-45 насны 26, 46-55 насны 7, 55 болон түүнээс дээш, жирэмсэн 1 иргэн бүртгэгдсэн байна. Сумын Эрүүл мэндийн төвд нийт 6 өвчтөн хэвтэн эмчлүүлж байна.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээллийг “Шаамар ЗДТГ”, “Шаамарынхан”, “Шаамар ЕБС”, “Бид Шаамарынхан”, “Шаамар Эрүүл мэндийн төв”, “Шаамар Соёлын төв”, “Шаамар зар”, “Шаамар сум”, “Шаамар МСҮТ”, “Шаамар 1-р цэцэрлэг”, “Шаамар 2-р цэцэрлэг”, “Дулаанхаан сайхан нутаг” зэрэг цахим хаягуудад байршуулан иргэдэд хүргэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2021 оны “2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” А/115 тоот захирамжийн дагуу сумын хэмжээнд ургацын урьдчилсан тогтоолт явуулах, ургац хураалтыг чанартай зохион байгуулахад, төр төсөв, албан байгууллагын өвөлжилтийн бэлтгэл ажилд, мал аж ахуйн урьдчилан сэргийлэх, иргэдээр хадлан тэжээл бэлтгүүлэх зэрэгт хяналт тавьж ажиллаж байна.

Дэлгэрхаан 1-р багт шинээр хадлангийн газар хүссэн 20 иргэнээс өргөдөл ирснээс 1 иргэний өргөдлийг буцаасан 17 иргэнд шинээр хадлангийн талбай хувиарласан 2 иргэний өргөдлийг шийдвэрлээгүй байна. Дэлгэрхаан 1-р багт 115 иргэнтэй гэрээ хийж 1669 га талбай иргэдэд олгосон. Охиндий 2-р багт хадлангийн газар үерт автсаны улмаас 43 иргэнээс өргөдөл ирснээс 31 иргэнд хадлангийн газар хувиарлаж, 4 иргэний өргөдлийг буцаасан, 8 иргэний өргөдлийг шийдвэрлээгүй байна. 2021 онд Охиндий багт нийт 66 иргэд 570 га хадлангийн газрын гэрээ хийгдсэн.

Улаанбуудай 4 ААН 825 га талбай, овьёос 1 ААН 2 иргэн 13 га, 2 ААН, 7 иргэн ногоон тэжээл 206 га, рапс 2 аан 1850 га, 200 гаруй өрх төмс 94 га, хүнсний ногоо 232.га талбайд тариалсан 2021 оны намрын ургац хураалт төмс 20 га талбайгаас 240 тн, хүнсний ногоо 56.3 га талбайгаас 607 тн, улаанбуудай 30 га талбайгаас 45 тн ургац хураан аваад байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах” А/272 тоот захирамжийн хүрээнд сумын Засаг даргын захирамжийг гарган холбогдох мэргэжилтэн, албан тушаалтнуудыг томилгоожуулан ажиллаж байна.

Шаамар сумын хогийн цэгийн хогийг түрж ажилласан. Шаамар 6-аас Зүүнбүрэн орох хүртэл замын трассын модноос гарсан хэрэгцээний мод, шургайг, банз, палк зэргийг 60 гаруй өрхөд хувиарлан олгосон.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНТУЯА